

ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



“ТӨРИЙН БОЛОН ОРОН НУТГИЙН ӨМЧИТ, ӨМЧИЙН ОРОЛЦООТОЙ ХУУЛИЙН ЭТГЭЭДИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР АШИГ” ГҮЙЦЭТГЭЛИЙН АУДИТЫН ТАЙЛАН

“ОРОН НУТГИЙН ӨМЧИТ ХУУЛИЙН ЭТГЭЭДИЙН ҮЙЛ
АЖИЛЛАГААНЫ ҮР АШИГ ЗОРИЛТОТ ТҮВШИНД ХҮРЭЭГҮЙ БАЙНА”

АУДИТЫН КОД: ХӨА-2022/22-21-ШТА-ГА

Дарга, Тэргүүлэх аудитор А.Эрдэнэбаатар

Утас: 88883317 Цахим хаяг: erdenebaatara@audit.gov.mn

Аудитын менежер Б.Тэгшдэлгэр

Утас: 99089114 Цахим хаяг: tegshdelgerb@audit.gov.mn

Ахлах аудитор Г.Эрдэнэчимэг

Утас: 99016320 Цахим хаяг: erdenechimegg@audit.gov.mn

Аудитор С.Гансүх

Утас: 95908400 Цахим хаяг: gansukhsa@audit.gov.mn

Аудитор Л.Мандахнаран

Утас: 92118277 Цахим хаяг: mandakhnaranl@audit.gov.mn

Хөвсгөл аймаг
2022 он

Энэхүү тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дараах
хаягаар авна уу. Цахим хуудас: www.khuvsgul.audit.mn

АГУУЛГА

Агуулга	Хуудасны дугаар
Товчилсон үгийн тайлбар	4
Аудит хийх үндэслэл, зорилт, хамрах хүрээ, хязгаарлалт, арга зүй, бүрэлдэхүүн, үндсэн мэдээлэл, хүндрэл бэрхшээл	5-7
Үндсэн мэдээлэл	8
БҮЛЭГ 1. Төрийн болон орон нутгийн өмчит, өмчийн оролцоотой компанийн засаглалыг хөгжүүлэх төрийн бодлогын хэрэгжилт хангалтгүй байна.	8
1.1 Төрийн болон орон нутгийн өмчит, өмчийн оролцоотой компанийн засаглалыг хөгжүүлэх бодлогын хэрэгжилт хангалтгүй байна.	8
1.2. Засгийн газрын 2016-2020, 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрт тусгасан төрийн болон орон нутгийн өмчийн засаглалыг сайжруулах зорилтын хэрэгжилт бүрэн хангагдаагүй байна.	10
БҮЛЭГ 2. Төрийн болон орон нутгийн өмчит, өмчийн оролцоотой хуулийн этгээдийн үйл ажиллагааны үр ашиг өссөн байна.	14
2.1.Төрийн болон орон нутгийн өмчит, өмчийн оролцоотой хуулийн этгээдийн зорилтот түвшинг үндэслэлтэй төлөвлөж, хянаж батлаагүй байна.	14
2.2.Төрийн болон орон нутгийн өмчит, өмчийн оролцоотой хуулийн этгээдийн орлого бүрдүүлэлт зорилтот түвшиндээ хүрээгүй байна.	16
2.3.Төрийн болон орон нутгийн өмчит, өмчийн оролцоотой хуулийн этгээдийн үйл ажиллагаа зорилт түвшнийг хангаж, үр ашиг нэмэгдсэн байна.	18
2.4.Төрийн болон орон нутгийн өмчит, өмчийн оролцоотой хуулийн этгээдийн санхүүгийн үйл ажиллагаа зардал үр ашгийн зохистой харьцаа хангагдаж байна.	20
БҮЛЭГ 3.Төрийн болон орон нутгийн өмчит, өмчийн оролцоотой хуулийн этгээдэд тавих хяналт үр нөлөөгүй байна.	27
3.1 Аймгийн Засаг даргын зүгээс болон Орон нутгийн өмчийн газар үр нөлөөтэй хяналт хэрэгжүүлээгүй байна.	27
3.2. Орон нутгийн өмчийн компаниудын ТУЗ-ын дэргэдэх дотоод аудит, эрсдэлийн удирдлага үр нөлөөгүй байна.	28
Аудитын дүгнэлт	30
Зөвлөмж	31
Зөрчлийн жагсаалт	32
Акт, Албан шаардлага	40
Хавсралт	42
Холбогдох байгууллагын санал	44

Товчилсон үгийн тайлбар

АДБОУС	Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт
МУ	Монгол улс
ХБНГУ	Холбооны бүгд найрамдах герман улс
УИХ	Улсын их хурал
ЗГ	Засгийн газар
АИТХ	Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал
АИТХТ	Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчид
АЗД	Аймгийн Засаг дарга
ГХБХБГ	Газрын харилцаа барилга хот байгуулалтын газар
БЗХТ	Барилга захиалагчийн хяналтын төв
УСНББОУС	Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн стандарт
НББОУС	Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт
ТБОНӨХБАҮХАТХ	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль
ААНОАТ	Аж ахуйн нэгжийн орлогын албан татвар
ААНТЗТХ	Аж ахуйн нэгжийн тусгай зөвшөөрлийн тухай хууль
ТАХ	Төсөл, арга хэмжээ
ХО	Хөрөнгө оруулалт
ХАА	Худалдан авах ажиллагаа
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар
ЕБС	Ерөнхий боловсролын сургууль
ЗДТГ	Засаг даргын Тамгын газар
СХАА	Санхүүгийн хяналт аудитын алба
ТУЗ	Төлөөлөн удирдах зөвлөл
ОНӨГ	Орон нутгийн өмчийн газар
ОНӨҮГ	Орон нутгийн өмчит үйлдвэрийн газар
ОНӨААТҮГ	Орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар
ХК	Хувьцаат компани
ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани
ТӨХК	Төрийн өмчит хувьцаат компани
СДОА	Сум дундын ойн анги
МХГ	Мэргэжлийн хяналтын газар

**Аудит хийх
үндэслэл,
бүрэн эрх**

Аудитыг Монгол Улсын Их Хурлын Төсвийн байнгын хорооны “Аудитын сэдэв батлах тухай” 2021 оны 6 дугаар тогтоол, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2022 оны А/12 дугаар тушаалаар баталсан “Төрийн аудитын байгууллагын 2022 оны гүйцэтгэлийн төлөвлөгөө”, Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газрын 2022 онд гүйцэтгэх аудитын төлөвлөгөөний дагуу Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1-д заасан бүрэн эрхийн хүрээнд гүйцэтгэлээ.

**Аудитын
зорилт**

Төрийн болон орон нутгийн өмчит, өмчийн оролцоотой зарим хуулийн этгээдийн компанийн засаглал, үйл ажиллагааны үр ашиг, хяналтын үр нөлөөг үнэлж дүгнэн, аудитын дүн, дүгнэлтэд үндэслэн зөвлөмж боловсруулж, аудитын тайланг Үндэсний аудитын газар болон аймгийн ИТХ, аймгийн Засаг дарга, холбогдох байгууллага, албан тушаалтанд танилцуулахад аудитын зорилго чиглэгдлээ.

Аудитын зорилтыг хангахын тулд дараах дэд зорилтын хүрээнд аудитыг гүйцэтгэсэн. Үүнд:

1. Компанийн засаглалыг хөгжүүлэх төрийн бодлого үр дүнтэй эсэх;
2. Төрийн болон орон нутгийн өмчит, өмчийн оролцоотой хуулийн этгээдийн үйл ажиллагаа үр ашигтай эсэх
3. Төрийн болон орон нутгийн өмчит, өмчийн оролцоотой хуулийн этгээдэд тавих хяналт үр нөлөөтэй эсэх

**Аудитын
хамарсан
хүрээ**

Аудитад Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль, Компанийн тухай хууль, УИХ-ын тогтоол, Засгийн газрын тогтоол, тухайн хуулийн этгээдийн ТУЗ-ийн шийдвэр, бусад холбогдох хууль, эрх зүйн баримт бичгийн хэрэгжилтийн хүрээнд Хөвсгөл аймгийн төрийн болон орон нутгийн өмчит, өмчийн оролцоотой хуулийн этгээдийн засаглал, үйл ажиллагааны үр ашиг, хяналтыг хэрэгжүүлэхэд оролцогч хувьцаа эзэмшигч, ТУЗ, гүйцэтгэх удирдлага, төрийн захиргааны болон мэргэжлийн байгууллага тэдгээрийн ажлын албадын 2019-2021 оны үйл ажиллагааг хамруулан гүйцэтгэлээ.

Хөвсгөл аймагт орон нутгийн өмчит, өмчийн оролцоотой 26 хуулийн этгээд бүртгэлтэй байна. Салбарын онцлог, үйл ажиллагааны чиглэл, ашиг алдагдлын хэмжээнээс хамааруулан нийт олонлогийг төлөөлөхүйц 10 хуулийн этгээдийг түүврээр сонгон авч үзлээ. Үүнд: Хөвсгөл АЗЗА ТӨХК, Хөвсгөл Эрчим хүч ХХК, Хөвсгөл ус суваг ХХК, Мөрөн хот тохижилт үйлчилгээний төв ХХК, Шинэ Мөрөн худалдааны төв ХХК, Эмийн эргэлтийн сан ХК, Могой гол ХК, Тэсийн илч ХХК, Галт дулаан ХХК, Түнэл илч ХХК

Аудитад аймгийн ИТХ, ОНӨГ, аймгийн ЗДТГ, Төрийн болон орон нутгийн өмчит, өмчийн оролцоотой зарим хуулийн этгээдүүд, мэргэжлийн байгууллага, бусад холбогдох байгууллагыг хамрууллаа.

**Аудитын
арга зүй,
шалгуур
үзүүлэлт**

Аудитыг гүйцэтгэхэд Аудитыг АДБОУБ (INTOSAI)-ын Стандартын хорооноос баталсан АДБОУС-100, АДБОУС-300, АДБОУС-3000-д нийцүүлэн баталсан Монгол улсын Төрийн аудитын стандарт MNS 6817-1:2020 “Төрийн аудитын тулгуур зарчим”, MNS 6817- 5:2020 “Төрийн аудитын Гүйцэтгэлийн аудитын тулгуур зарчим”, MNS 6817-7:2020 “Төрийн аудитын Гүйцэтгэлийн аудит”-ын стандарт, МУ-ын Ерөнхий аудиторын “Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журам”, “Гүйцэтгэлийн аудитын заавар, аргачлал”-ыг ашигласан болно.

Аудитаар “Төрийн болон орон нутгийн өмчит, өмчийн оролцоотой хуулийн этгээдийн үйл ажиллагааны үр ашиг”-т оролцогч хуулийн этгээдийн компанийн засаглалыг хэрэгжүүлэх эрх зүйн орчин, Засгийн газрын 2016-2020, 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрт тусгасан холбогдох бодлогын зорилтын хэрэгжилт, хуулийн этгээдийн эдийн засгийн зорилтот

түвшний төлөвлөлт, хяналт, санхүүгийн үйл ажиллагаа, үр ашигт судалгаа хийх, нэгтгэсэн дүн шинжилгээ, харьцуулалт хийх, мэдээллийн ил тод нээлттэй байдал, хяналтын тогтолцооны үр нөлөө зэрэг үйл ажиллагааны төлөвлөлт, хэрэгжилт, тайлагналыг холбогдох баримт материалыг үндэслэн тулган баталгаажуулах, үнэлгээ хийх, асуудал хариуцсан албан тушаалтантай ярилцлага хийх, асуулга лавлагаа, тодруулга авах зэрэг аудитын горимыг хэрэгжүүлж ажиллана.

Аудитын асуудлын шинжилгээ, арга зүйн дагуу нотлох зүйлс цуглуулж, түүнд үндэслэн аудитын дүн, дүгнэлт гарган зөвлөмж боловсруулав. /Хавсралт №2, Хавсралт №3/

Аудитад ашиглах шалгуур үзүүлэлтүүд:

Аудитад дараах хууль, эрх зүйн актуудыг шалгуур үзүүлэлтийн эх сурвалж болгон ашиглалаа. Үүнд:

Хууль

- Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль /1996/
- Компанийн тухай хууль /2011/
- Төрийн болон орон нутгийн өмчөөр хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль /2005/
- Авлигын эсрэг хууль /2006/
- Төсвийн тухай хууль /2011/
- Төрийн албаны тухай хууль /2017/
- Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль /2006, 2021/
- Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль /2012/
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль /2015/
- Татварын ерөнхий хууль /2019/
- Дээрх хууль, эрх зүйн актуудтай нийцүүлэн гаргасан гаргасан дүрэм, журам, норм норматив, стандарт, холбогдох бусад шийдвэр

Улсын Их Хурлын тогтоол

- УИХ-ын 2016 оны 19 дүгээр тогтоол “Монгол Улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030”
- УИХ-ын 2016 оны 45 дугаар тогтоол “Монгол Улсын Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр”
- УИХ-ын 2020 оны 52 дугаар тогтоолоор баталсан “Алсын хараа-2050” урт хугацааны хөгжлийн бодлогын баримт бичиг
- УИХ-ын 2020 оны 24 дүгээр тогтоолоор баталсан “Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр”
- УИХ-ын 2020 оны 23 дугаар тогтоолоор баталсан “Монгол Улсын 2021-2025 оны хөрөнгө оруулалтын хөтөлбөр”
- УИХ-аас гаргасан холбогдох бусад тогтоол

Засгийн Газрын тогтоол

- ЗГ-ын 2011 оны 69 дүгээр тогтоол “Компанийн Засаглалыг хөгжүүлэх үндэсний хөтөлбөр”
- ЗГ-ын 2016 оны 80 дугаар тогтоол “Төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдэд төрийн өмчийн төлөөллийг хэрэгжүүлэх журам”
- ЗГ-ын 2016 оны 91 дүгээр тогтоол “Сангийн яамны үйл ажиллагааны стратеги, бүтцийн өөрчлөлтийн хөтөлбөр”
- ЗГ-ын 2011 оны 311 дүгээр тогтоол “Аж ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагаанд дотоод хяналт шалгалтыг зохион байгуулах нийтлэг журам”
- ЗГ-аас гаргасан холбогдох бусад тогтоол, шийдвэрүүд

Бусад холбогдох эрх зүйн баримт бичгүүд

**Аудитын
бүрэлдэхүүн,
хугацаа**

- Санхүүгийн зохицуулах хорооны 2014 оны 162 дугаар тогтоолоор баталсан “Компанийн засаглалын кодекс”
- Санхүүгийн зохицуулах хорооны 2016 оны 34 дүгээр тогтоолоор баталсан “Компанид засаглалын үнэлгээ хийх, түвшин тогтоох журам”
- Байгууллагын засаглалын олон улсын удирдамж ISO 37000 стандарт
- Эдийн засгийн хамтын ажиллагаа, хөгжлийн байгууллагаас гаргасан Компанийн засаглалын зарчмууд
- УСНББОУС, НББОУС болон бусад стандартууд
- Татварын ерөнхий газрын даргын 2017 оны А/06 тушаалаар баталсан “Татвар төлөгчийг бүртгэх журам”
- Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2019 оны 260 дугаар тогтоолоор баталсан “Төрийн өмчит үйлдвэрийн газар, төрийн өмчит компанийн захиралтай контракт байгуулах, дүгнэх журам”
- Эрчим хүчний төрийн өмчит компанийн хувьцаа эзэмшигчдийн хурлын 2019 оны 02 дугаар тогтоолоор баталсан “Эрчим хүчний салбарын төрийн өмчит компанийн гүйцэтгэх захиралтай байгуулсан контрактыг дүгнэх, урамшуулал олгох түр журам”

Аудитыг Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор А.Эрдэнэбаатар хянан удирдаж, үе шатны чанарын хяналтыг аудитын менежер Б.Тэгшдэлгэр хэрэгжүүлж, ахлах аудитор Г.Эрдэнэчимэг, аудитор С.Гансүх, Л.Мандахнаран нар батлагдсан төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу хийж гүйцэтгэлээ.

Аудитын урьдчилсан судалгаа, төлөвлөлтийн үе шатны ажлыг 2022 оны 4 дүгээр сарын 20-ны өдрөөс эхлэн 2022 оны 4 дүгээр сарын 29-ний өдрийн дотор гүйцэтгэж, аудитын төлөвлөгөөг Тэргүүлэх аудитораар батлуулсан.

Аудитын талбарын ажлыг 2022 оны 5 дугаар сарын 02-ны өдрөөс эхлэн 6 дугаар сарын 15-ны дотор гүйцэтгэх бөгөөд аудиторуд талбарын ажлын дэд тайланг зэрэгцүүлэн бичиж, үе шатны чанарын хяналтыг хийлгэсэн.

Аудитын тайланг 2021 оны 7 дугаар сарын 01-ний өдрийн дотор дуусан тэргүүлэх аудиторовн тушаалаар баталгаажуулан 2021 оны 7 дүгээр сарын 01-ний өдрийн дотор Үндэсний аудитын газар болон аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Засаг дарга холбогдох албан тушаалтанд хүргүүлээ.

Аудитын тайланд дэвшүүлсэн зорилт, хамарсан хүрээ, аудитын дүн, дүгнэлт, зөвлөмжөөс гадна холбогдох байгууллагын саналыг тусгалаа.



ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОРЫН ТУШААЛ

2022 оны 06 сарын 29 өдөр

Дугаар А/12

Мөрөн сум

Аудитын тайланг баталгаажуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.4, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2022 оны “Аудитын жилийн төлөвлөгөө батлах тухай” А/12 дугаар тушаал, 2020 оны 12 дугаар сарын 22-ны өдрийн А/106 дугаар тушаалын хавсралтаар батлагдсан “Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журам”-ын 18.9, 2018 оны А/207 “Эрх үүрэг шилжүүлэх тухай” дугаар тушаалын 5 дугаар хавсралтын 2.4 дэх заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. “Төрийн болон орон нутгийн өмчит, өмчийн оролцоотой хуулийн этгээдийн үйл ажиллагааны үр ашиг” гүйцэтгэлийн аудитын тайланг нэгдүгээр хавсралтаар, аудитаар өгсөн албан шаардлагын жагсаалтыг хоёрдугаар хавсралтаар баталсугай.

2. Аудитын тайланг Үндэсний аудитын газрын гуравдугаар газар болон аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Засаг дарга, Орон нутгийн өмчийн газар, Могойн гол ХК, Хөвсгөл эрчим хүч ХХК, Галт дулаан ХХК-ийн дарга, гүйцэтгэх захирал нарт тус тус хүргүүлсүгэй.

3. “Төрийн болон орон нутгийн өмчит, өмчийн оролцоотой хуулийн этгээдийн үйл ажиллагааны үр ашиг” гүйцэтгэлийн аудитаар өгсөн албан шаардлага, зөвлөмжийг хэрэгжүүлэн ажиллаж үр дүнг 2022 оны 11 дүгээр сарын 01-ний өдрийн дотор багтаан Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэхийг дээрх байгууллагын дарга нарт зөвлөсүгэй.

4. Аудитаар өгсөн албан шаардлага, зөвлөмжийн биелэлтэд хяналт тавьж, хэрэгжилтийг хангуулан ажиллахыг Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор /Г.Эрдэнэчимэг/-т үүрэг болгосугай.

5. Энэхүү тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газрын хэлтсийн дарга, аудитын менежер /Б.Тэгшдэлгэр/-т даалгасугай.

6. Аудитын ажлын болон нотлох баримтыг 2022 оны 07 дугаар сарын 08-ны өдрийн дотор архивын нэгж болгон архивд хүлээлгэн өгөхийг аудитын баг /ахлах аудитор Г.Эрдэнэчимэг/-т үүрэг болгосугай.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР

А.ЭРДЭНЭБААТАР

1720090001-0076605

Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газрын
даргын 2021 оны 6 дугаар сарын 29-ны
өдрийн А/12 дугаар тушаалын нэгдүгээр
хавсралт

АКТ, АЛБАН ТУШААЛЫН ЖАГСААЛТ

1720000001 0070605

№	Зөрчлийн утга	Байгууллага	Албан тушаалтан
1	Могойн гол ХК 20.0 сая төгрөгийн хандив өгсөн байна.	Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн хурал	нарийн бичгийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Б.Машбат
2	Могойн гол ХК нь Төлөвлөгдөөгүй зардалд 30.0 сая төгрөг зарцуулсан байна	Могойн гол ХК	Захирал Б.Батхүү
3	Цагаан-Уул сумын Дулааны шугам сүлжээ, зуухны шинэчлэлтийн ажилд техникийн болон зохиогчийн хяналт хийгдээгүй, ашиглалтад оруулах улсын комисс үр дүнгүй ажилласан, улсын комисс зөрчил арилсан эсэхэд дахин хяналт хийгээгүй, зөрчил арилаагүй байна.	Цагаан сум	Засаг дарга С.Гончигням

Үндсэн мэдээлэл

УИХ-ын 2020 оны 52 дугаар тогтоолоор баталсан “Алсын хараа -2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын баримт бичгийн 5.2.19-т “Төрийн өмчит компанийн засаглалыг сайжруулж, үр ашгийг нэмэгдүүлэн, өмч хувьчлалыг үе шаттай, үр дүнтэй явуулна”, “Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-ийн 4.4.10-т “Төрийн болон орон нутгийн өмчийн бүртгэл, ашиглалт, хамгаалалтыг сайжруулж, төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн засаглалыг олон улсын жишигт нийцүүлэн, газрын хууль тогтоомжийг төрийн байгууламж нэгдмэл байх зарчим болон өмчийн эрх зүйд нийцүүлэн боловсронгуй болгоно” гэж тус тус заасан байна.

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийг 1996 онд баталсан бөгөөд тус хуульд 29 удаа нэмэлт өөрчлөлт оруулсан байна. Уг хуульд орон нутгийн өмчийн талаар дараах байгууллагын эрхийг хуульчилсан байна.

Аймгийн ИТХ:

- Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал нь тухайн аймаг, нийслэл, сум, дүүргийн өмчийн зүйлсийг хүн амаа төлөөлөн өмчлөгч нь байна.
- Орон нутгийн өмчийн эд хөрөнгийн хадгалалт, хамгаалалтын байдлыг хянан шалгах буюу түүнд тавих хяналт шалгалтыг зохион байгуулах;
- Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчид, Засаг даргаас орон нутгийн өмчийн хөрөнгийг эзэмших, ашиглах, захиран зарцуулах эрхээ хэрэгжүүлэх талаар зохиосон ажил, үр ашгийн тайлан, нэгдсэн тооллогын дүнг жил бүр хэлэлцэж, дүгнэлт, чиглэл өгөх;
- Орон нутгийн өмчийн үндсэн хөрөнгийг хувьчлах ба бусдад шилжүүлэх, шинээр олж авах жагсаалт, төлөвлөгөө, эх үүсвэрийг хэлэлцэж батлах. Хувьчлах орон нутгийн эд хөрөнгийн жагсаалтыг батлахдаа Төрийн өмчийн хороотой зөвшилцөнө;
- Орон нутгийн өмчийн хуулийн этгээд байгуулах, өөрчлөн байгуулах, татан буулгах шийдвэр гаргаж, гүйцэтгэлд нь хяналт тавих

Аймгийн Засаг дарга:

Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас орон нутгийн өмчийн эд хөрөнгийн талаар гарсан шийдвэрийг Засгийн газрын бодлогод нийцүүлэн хэрэгжүүлэх үүрэгтэй.

Хуульд өөрөөр заагаагүй бол Засаг дарга дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

- Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас олгосон эрх хэмжээний дотор орон нутгийн өмчийг эзэмших, ашиглах, захиран зарцуулах;
- Орон нутгийн өмчит хуулийн этгээдийн эрх баригчийг томилох;
- Орон нутгийн өмчийн төлөөлөгчийг томилох, өөрчлөх саналаа Хурлын Тэргүүлэгчдэд оруулах;
- Орон нутгийн өмчийн эд хөрөнгийн нэгдсэн бүртгэл хөтлөх, эд хөрөнгийн тооллого явуулах ажлыг зохион байгуулах;
- Орон нутгийн өмчит албан байгууллагыг шаардлагатай эд хөрөнгөөр хангах;
- Орон нутгийн өмчийн эд хөрөнгийг төрийн өмчийн бодлого, зохицуулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын мэргэжил, арга зүйн удирдлагын дор хувьчлах ажлыг зохион байгуулах;
- Орон нутгийн өмч эрхэлсэн ажилтан буюу албыг шуурхай удирдах.

Төрийн чиг үүргийг хэрэгжүүлэх болон нийгмийн хэрэгцээг хангах зорилгоор Хөвсгөл аймагт 27 төрийн болон орон нутгийн өмчит, өмчийн оролцоотой хуулийн этгээд уул уурхай, эрчим хүч, нисэх буудал, дулаан түгээх, ус түгээх, хот тохижилтын үйлчилгээ, ойн аж ахуй, эмийн худалдаа зэрэг чиглэлээр үйл ажиллагаа явуулж байна.

Төрийн өмчит дараах хуулийн этгээдүүд байна. Үүнд:

- Хөвсгөл дулааны станц ТӨХК
- Иргэний нисэхийн ерөнхий газрын харьяа Мөрөн нисэх буудал
- Хөвсгөл АЗЗА ТӨХК

Хөвсгөл аймгийн орон нутгийн өмчит болон өмчийн оролцоотой хуулийн этгээдийн нийт хөрөнгийн хэмжээ 75,686.6 сая төгрөг байна.

Хөвсгөл аймгийн орон нутгийн өмчит болон өмчийн оролцоотой хуулийн этгээдийн санхүүгийн үзүүлэлтээр Аж ахуйн нэгжийн орлогын албан татварт 2020 онд 7 компани 296.0, 2021 онд 11 компани 252.9 сая төгрөг төлсөн байна

БҮЛЭГ 1. Төрийн болон орон нутгийн өмчит, өмчийн оролцоотой компанийн засаглалыг хөгжүүлэх төрийн бодлогын хэрэгжилт хангалтгүй байна.

1.1.Төрийн болон орон нутгийн өмчит, өмчийн оролцоотой компанийн засаглалыг хөгжүүлэх бодлогын хэрэгжилт хангалтгүй байна.

1.1.1. Орон нутгийн өмчит, өмчийн оролцоотой хуулийн этгээдийн компанийн засаглал, үйл ажиллагааг хөгжүүлэх бодлогын хэрэгжилт үр дүнгүй байна.

Хөвсгөл аймагт 2021 оны жилийн эцсийн байдлаар төрийн өмчийн 3 компани, орон нутгийн өмчийн 22 компани, орон нутгийн өмчийн оролцоотой 1 компани үйл ажиллагаа явуулж байна.

Эдгээр хуулийн этгээдүүдийн бүртгэлийн хэлбэрээр авч үзвэл ТӨХК 2, ТӨХК-ийн салбар 1, ХК 3, ХХК 11, ОНӨҮГ 9, Үйл ажиллагааны чиглэлээр нь авч үзвэл Уул уурхайн ашиглалтын 1, Цахилгаан түгээх 1, Дулаан үйлдвэрлэх, түгээх 8, Худалдаа үйлчилгээний 14 байна.

Компанийн тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.8¹. заалтаас зөрүүтэй хуулийн этгээдийн бүртгэлтэй орон нутгийн өмчит Хөвсгөл эмийн эргэлтийн сан ХК байна.

Үүрийн долгио ХК нь МУИХ-ын 1999 оны 29 дүгээр тогтоолоор төрийн өмчөөс аймагт шилжин ирсэн /төрийн өмчийн эзлэх хувь 32.3, нийт хөрөнгийн хэмжээ 12.4 сая төгрөг бөгөөд төрийн өмчийн эзлэх хувь 2.8 сая төгрөг/ хөрөнгө бөгөөд хаана хэн харьяалж байгаа нь тодорхойгүй, бүртгэл мэдээлэлгүй компани байна.

Компанийн тухай хуульд хувьцаат компани болон төрийн өмчийн компанийн төлөөлөн удирдах зөвлөл нь ес буюу түүнээс дээш гишүүнтэй байх ба тэдгээрийн гуравны нэгээс доошгүй хувь нь хараат бус гишүүн байхаар заасан байна.

Орон нутгийн өмчит ХХК-ийн ТУЗ-ын бүрэлдэхүүн харилцан адилгүй байна.

Хүснэгтээр харуулбал:

Хүснэгт №1					
№	Хуулийн этгээдийн нэр	Хариуц лагын хэлбэр	ТУЗ- ийн гишүүн ий тоо	Хараат бус гишүүн ий тоо	Хара ат
1	"Могойн гол" ХК	ХК	9	3	6
2	"Хөвсгөлийн эмийн эргэлтийн сан" ХХК	ХК	9	3	6
3	"Хөвсгөл Эрчим хүч" ХХК	ХХК	9	3	6
4	"Хөвсгөл Ус суваг" ХХК	ХХК	9	3	6
5	"Шинэ Мөрөн худалдааны төв" ХХК	ХХК	9	3	6
6	Их-Уул сумын "Их-Уул Дулаан" ХХК	ХХК	5		5
7	Тариалан сумын "Нийтийн ахуй үйлчилгээний төв" ХХК	ХХК	5		5
8	Тосонцэнгэл сумын Тосон-Илч ХХК	ХХК	5		5
9	Түнэл сумын "Түнэл-Илч" ХХК	ХХК	5		5
10	Цагаан-Уул сумын "Галт дулаан" ХХК	ХХК	5		5
11	"Эрчим Илч түлш" ХХК	ХХК	5		5

¹ "Хаалттай хувьцаат компани" гэж хувьцаа эзэмшигчийн оруулсан хөрөнгө нь хувьцаанд хуваагдаж, хувьцаа нь үнэт цаасны хадгаламжийн үйл ажиллагаа эрхлэх байгууллагад бүртгэгдэж, үнэт цаасны арилжаа эрхлэх байгууллагаас гадуур зах зээлд хаалттай хүрээнд арилжаалагддаг компанийг хэлнэ

12	“Мөрөн хот тохижилт үйлчилгээний төв” ХХК	ХХК	5	5
13	“Тэсийн-Илч” ХХК	ХХК	5	5
14	“Шинэ-Идэр Дулаан Эрдэнэт” ХХК	ХХК	5	5

Судалгаанаас харахад орон нутгийн өмчит компаниудын төлөөлөн удирдах зөвлөлийн бүрэлдэхүүн 5-9 тооны гишүүнтэй, ОНӨҮГ-т удирдлагын зөвлөл ажиллаж байна.

Компанийн төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүн болон төлөөлөн удирдах зөвлөлийн нарийн бичгийн дарга нь компанийн засаглалын чиглэлээр сургалтад хамрагдаж, гэрчилгээ авах хуулийн зохицуулалтыг бүрэн хангахгүй байна. Тухайлбал: Галт дулаан ХХК-ийн ТУЗ-ын 5 гишүүн Компанийн тухай хуулийн 75 дугаар зүйлийн 75.8²-д заасан засаглалын сургалтын гэрчилгээгүй тул ТУЗ-аас чөлөөлөх албан шаардлага хүргүүлж байна.

Орон нутгийн өмчийн компанийн төлөөлөн удирдах зөвлөлд тусгай шаардлага хангасан нэр дэвшигчийг нээлттэй ил тод сонгон шалгаруулалтын үндсэн дээр томилогсон гэх нотлох баримтгүй байна.

Дээрх байдлаас дүгнэхэд орон нутгийн жижиг компанид төлөөлөн удирдах зөвлөл байх, гишүүдийн тоо их эс байх нь удирдлагын зардлыг нэмэгдүүлэх нэг шалтгаан болж байгаа тул Компанийн тухай хуулийн 75 дугаар зүйлийн 75.2.”Хувьцаат компани нь төлөөлөн удирдах зөвлөлтэй байх бөгөөд хязгаарлагдмал хариуцлагатай компанийн дүрэмд өөрөөр заагаагүй бол төлөөлөн удирдах зөвлөлгүй байж болно” заалтын дагуу төлөөлөн удирдах зөвлөлгүй байж болохоор байна.

Өрхийн эрүүл мэндийн төвүүд нь Нөхөрлөл хэлбэртэй байгаа нь Иргэний тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1.”Гишүүдийн оруулсан хувь хөрөнгөөс бүрдэх эд хөрөнгөтэй, хүлээсэн үүргээ уг эд хөрөнгө болон гишүүдийн хувийн өмчийн эд хөрөнгөөр хуульд заасны дагуу хариуцдаг хуулийн этгээдийг нөхөрлөл гэнэ” тодорхойлолтыг хангахгүй, төрийн эд хөрөнгө, төрийн санхүүжилтээр үйл ажиллагаа явуулдаг, хувь нийлүүлсэн гишүүдгүй байна.

Цагаан-Үүр сумын Үүрийн долгио ХК-д төрийн эзэмшлийн 27 хувь ногдож байгаа төрийн өмчийн хорооны 1999 оны 99 дугаар тогтоолоор Хөвсгөл аймагт хөрөнгө шилжиж ирсэн боловч ямар нэгэн хяналт, тайлан байхгүй, хувь хөрөнгийг эзэмшээгүй байна.

1.1.2. ТУЗ-ийн гишүүн сонгон шалгаруулах, томилоход аймгийн эрх бүхий байгууллагуудын ажлын уялдаа холбоо, чиг үүргийн биелэлт хангалтгүй байна.

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 77 дугаар зүйлд заасан Орон нутгийн өмчийн талаарх иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын бүрэн эрхийн хэрэгжилтийн талаар:

- Орон нутгийн өмчийн хуулийн этгээд байгуулах, өөрчлөн байгуулах, татан буулгах шийдвэр гаргаж, гүйцэтгэлд нь хяналт тавих чиг үүргийн хүрээнд:
 - Хоймор нутгийн чулуу ХХК-г үр ашиггүй ажилласан тул 2020 оны 107 тоот тогтоолоор татан буулгаж Хот тохижилт ХХК-д нэгтгэсэн

² 75.8.Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүн болон төлөөлөн удирдах зөвлөлийн нарийн бичгийн дарга нь компанийн засаглалын чиглэлээр сургалтад хамрагдаж, гэрчилгээ авсан байна.

- Хөвсгөл эмийн эргэлтийн сан ХК нь үр ашиггүй, өр төлбөртэй ажиллаж байгаа тул дуудлага худалдаа зохион байгуулах ажлын удирдамжийг 2021 оны 58 дугаар тогтоолоор баталсан байна.
- Мөрөн сумын Хот тохижилт үйлчилгээний төвийн хуулийн этгээдийн бүртгэлд өөрчлөлт оруулж Хот тохижилт ХХК болгон өөрчлөн байгуулсан байна.
- “Захиалагчийн хяналтын төв” ОНӨААТҮГ-ыг аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2020 оны 75 дугаар тогтоолоор байгуулан ажиллуулсны үр дүнд 2020 онд улс, орон нутгийн төсвийн хөрөнгөөр худалдан авсан барилга, байгууламжийн ажилд хяналт тавих иж бүрэн тогтолцоо бий болсон байна.

2. Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 77 дугаар зүйлд “Хурлын дарга нь тухайн хурлын хуралдааны чөлөөт цагт энэ зүйлийн 2 дахь хэсэгт заасан бүрэн эрхийг хэрэгжүүлж иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд хариуцан тайлагнахаас гадна орон нутгийн өмчийн оролцоотой хувь нийлүүлсэн хуулийн этгээдэд өмчийн төлөөлөгчийг томилж түүний үйл ажиллагааг чиглүүлнэ” чиг үүргийн хүрээнд Могойн гол ХК-ийн орон нутгийн өмчийн төлөөлөгчийг 2019 он, 2020 он, 2021 онд томилсон байна.

Аймгийн Засаг даргын Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 78 дугаар зүйлд заасан бүрэн эрхийн хэрэгжилт дараах байдалтай байна:

- Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас олгосон эрх хэмжээний дотор орон нутгийн өмчийг эзэмших, ашиглах, захиран зарцуулах эрхийг Орон нутгийн өмчийн газраар дамжуулан хэрэгжүүлж байна. Үүнд: орон нутгийн өмчийн хөрөнгийн бүртгэл, тайлагналд хяналт тавьж нэгтгэн удирдаж АИТХ-д тайлагнаж шаардлагатай шийдвэрийг гаргуулан ажиллаж байна.

АИТХ-ын 2017 оны 02 дугаар тогтоолоор баталсан “Орон нутгийн өмчит компанийн төлөөлөн удирдах зөвлөлийн үйл ажиллагааны нийтлэг журам”-ын ТУЗ-ийн гишүүн сонгон шалгаруулах, томилох, аймгийн Засаг дарга нэр дэвшүүлэх асуудал 2021 оноос хойш хэрэгжилтгүй болсон байна. Учир нь АИТХ нь өөрөө ТУЗ-ийн гишүүнд нэр дэвшүүлээд баталдаг учраас аймгийн Орон нутгийн өмчийн газар, Засаг даргын зүгээс ТУЗ-д хяналт тавих боломжгүй байна.

Орон нутгийн өмчийн компаниудын ТУЗ-ийн чиг үүргийн хэрэгжилтийн талаар:

- Аймгийн шууд удирдлагатай Эрчим хүч ХХК, Хөвсгөл Ус суваг ХХК, Шинэмөрөн ХК, Хөвсгөл эмийн эргэлтийн сан ХК-ийн ТУЗ-ын дэргэдэх хороод АИТХТ-ын 2017 оны 02 дугаар тогтоолоор баталсан “Орон нутгийн өмчит компанийн төлөөлөн удирдах зөвлөлийн үйл ажиллагааны нийтлэг журам батлах тухай” журмын Ес зүгээр зүйлд заасан төлөөлөн удирдах зөвлөлийн хорооны чиг үүргийг хэрэгжүүлээгүй байна.

Хөвсгөл Эрчим хүч ХХК-ийн ТУЗ-ийн бүрэлдэхүүнд Т.Амартүвшин /2021 он, 2022 он/, С.Долгоржав /2019 он/, Х.Рагчаа /2022 он/ нарын төрийн үйлчилгээний ажилтнуудыг хараат гишүүнээр томилсон нь ТБОНӨТХ-ийн 21 дүгээр зүйлийн 5³. заалттай нийцэхгүй байна.

АИТХТ-ийн 2018 оны IX хуралдааны 04 тогтоолоор орон нутгийн өмчийн компаниудад ногдол ашиг тогтоож орон нутгийн орлогод төвлөрүүлэхээр

³ Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага болон энэ зүйлийн 2 дахь хэсгийн 3-т заасны дагуу тогтоосон этгээд төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн төлөөлөн удирдах зөвлөлийн бүрэлдэхүүнд төрийг төлөөлж оролцох гишүүдийг томилохдоо дараах болзлыг хангасан нэр дэвшигчдээс томилно: 3/төрийн захиргааны албан хаагч болон энэ зүйлийн 2 дахь хэсгийн 3-т заасны дагуу тогтоосон этгээдийн ажилтан байх”

шийдвэрлэсэн нь Компанийн тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.1⁴ хэсгийг зөрчсөн байна.

Компанийн дүрэмд заагаагүй үйл ажиллагааг явуулсан байна. Үүнд:

- Хөвсгөл Эрчим хүч ХХК нь 0.4-35 кв-ын цахилгаан дамжуулах шугам, дэд станцын угсралт, засварын ажил, түүний туршилт тохируулгын ажил үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрлийг 2021 оны 6 дугаар сарын 30-ны өдөр Эрчим хүчний яамны Сайдаас авсан байна. Үүнээс өмнө өөрийн хөрөнгөөр 0.4-35 кв-ын цахилгаан дамжуулах шугам, дэд станцын угсралт, засварын ажлыг гүйцэтгэсэн байна.
- Хөвсгөл Эмийн эргэлтийн сан ХК нь хүн ам, эрүүл мэндийн байгууллагуудыг харьяа салбар эмийн сангуудаар дамжуулан Монгол улсын эмийн бүртгэлд бүртгэгдсэн чанарын шаардлага хангасан эм, эмнэлгийн хэрэгслийн худалдаа эрхэлнэ” гэж компанийн дүрэмд заасан хэдий ч ААНТЗТХ-ийн 15.12.2-д заасан тусгай зөвшөөрөлгүйгээр эм хангамжийн үйл ажиллагаа эрхэлсэн байна.

1.2. Засгийн газрын 2016-2020, 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрт тусгасан төрийн болон орон нутгийн өмчийн засаглалыг сайжруулах зорилтын хэрэгжилт бүрэн хангагдаагүй байна.

1.2.1. Засгийн газрын болон аймгийн Засаг даргын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн орон нутгийн өмчит компаниудын ашигт ажиллагаа, засаглал, өмч хувьчлалын бодлогыг сайжруулах зорилт бүрэн хангагдаагүй байна.

Засгийн газрын 2016 оны 221 дүгээр тогтоолоор баталсан⁵ төлөвлөгөөний “Төрийн болон орон нутгийн өмчийн ашиглалт, төрийн болон орон нутгийн өмчит компаниудын ашигт ажиллагаа, засаглал, өмч хувьчлалын бодлогыг сайжруулж, төр, хувийн хэвшлийн түншлэлийг шинэ шатанд гаргана” зорилтыг Хөвсгөл аймгийн “Хөгжлийн хөтөч” хөтөлбөрт тусган хэрэгжүүлж ажилласан байна. Зорилтын хэрэгжилтийг хүснэгтээр харуулбал:

Хүснэгт №2

№	Зорилтын дугаар	Хэрэгжилтийн тайлан
2.1.4 Орон нутгийн өмчит үйлдвэрийн газруудын санхүүгийн чадавхыг дээшлүүлэх алдагдлыг бууруулах чиглэлийн зохион байгуулалтын арга хэмжээг авч, орон нутгийн өмчийн талаар баримтлах бодлогын баримт бичиг батлуулж хэрэгжүүлэх		
1	Орон нутгийн өмчит үйлдвэрийн газруудын менежментийг сайжруулах замаар алдагдлыг бууруулж, ашигтай ажиллах	Аймгийн ЗДҮАХ батлагдсанаас хойш нийт 35 аж ахуйн нэгжийн удирдлага зохион байгуулалт, хэлбэр, дүрэм журамтай холбоотой асуудлыг ИТХ-ын тогтоол гаргаж шийдвэрлүүлсэн байна. Орон нутгийн өмчит үйлдвэрийн газрыг татан буулгах, өөрчлөн байгуулах, хэлбэр өөрчлөх, дүрмийг шинэчлэх, нийтлэг журам батлахтай холбоотой 2016 онд аймгийн ИТХТ-ийн 9 тогтоол, 2017 онд 35 тогтоол, 2018 онд 3 тогтоол, 2019 онд 9 тогтоол гарсан байна. Орон нутгийн өмчит компанид төлөөлөл хэрэгжүүлэх төлөөлөн удирдах зөвлөлийг томилох, эдийн засгийн зорилтот түвшнийг тогтоосон тухай 39 шийдвэрийг боловсруулан батлуулж ажилласан байна. Орон нутгийн өмчит аж ахуйн нэгжүүдийн менежменттэй холбоотой дээрх шийдвэрүүдийг гарган ажилласнаар орон нутгийн өмчит болон өмчийн оролцоотой 33 компани 2016 онд нийт дүнгээрээ 181.2 сая төгрөгийн ашигтай

⁴ Компанийн дүрэмд өөрөөр заагаагүй бол төлөөлөн удирдах зөвлөл /байхгүй бол хувьцаа эзэмшигчдийн хурал/ ногдол ашиг хуваарилах эсэх тухай шийдвэрийг гаргах бөгөөд уг шийдвэрт хувьцаа бүрд ногдох ашгийн хэмжээ, ногдол ашиг авах эрхтэй хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалт гаргах өдөр болон ногдол ашиг төлөх өдөр зэргийг заана.

⁵ 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө

	нөхцөлийг хангана.	ажиллаж орон нутгийн төсөвт ногдол ашгаар 172.0 сая төгрөгийг төвлөрүүлсэн бол 2017 онд 672.2 сая төгрөгийн ашигтай, 2018 онд 12 компани 1,077.0 сая төгрөгийн ашигтай, 2019 онд 15 компани 302.0 сая төгрөгийн ашигтай ажилласан үр дүнтэй байна.
2	Улсын болон орон нутгийн өмчит үйлдвэрийн газрын зарим үйл ажиллагааг гэрээгээр гүйцэтгүүлж менежментийн хувьчлалд оруулна.	Арбулаг, Алаг-Эрдэнэ, Баянзүрх, Бүрэнтогтох, Галт, Жаргалант, Рашаант, Рэнчинлхүмбэ, Төмөрбулаг сумдын төсөвт байгууллага, айл өрх аж ахуйн нэгжийг төвлөрсөн дулаанд холбох, дулаанаар хангах үйл ажиллагааг төр хувийн хэвшлийн түншлэлийн гэрээгээр гүйцэтгүүлэх шийдвэр аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2017 оны 105 дугаар тогтоолоор гарч, үүний дагуу шугам сүлжээний ажил хийгдэж, 2018 онд Галт, Жаргалант, Төмөрбулаг, Рашаант, Бүрэнтогтох сумд төвлөрсөн дулаанд холбогдлоо. 2019 онд Цагаан-Уул сумын төвийн дулааны шугам сүлжээг төр, хувийн хэвшлийн түншлэлийн гэрээгээр хэрэгжүүлэх тухай Цагаан-Уул сумын ИТХТ-ийн саналыг аймгийн ИТХТ-ийн хуралд танилцуулж, 2019 оны 5 дугаар сарын 2-ны өдрийн 69 дүгээр тогтоолоор дэмжсэн шийдвэр гарсан бөгөөд шугам сүлжээг шинэчлэх ажлыг "Идэр нумт" ХХК гүйцэтгэн, шугам сүлжээний ажил хийгдэж дууссан бөгөөд шугам сүлжээний шинэчлэлийн ажил хийгдсэнээр өвөлжилтийн бэлтгэл хангагдаж, халаалтын үйл ажиллагаа хэвийн явагдах нөхцөл бүрдсэн.

Засгийн газрын болон Хөвсгөл аймгийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний хэрэгжилтээс харахад орон нутгийн өмчит компаниудын ашигт ажиллагаа, засаглал, өмч хувьчлалын бодлогыг сайжруулах зорилт бүрэн хэрэгжсэн гэж үнэлэх боломжгүй байна.

1.2.2. Засгийн газрын болон аймгийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн зорилтын хэрэгжилт үр дүн багатай байна.

Засгийн газрын 2020 оны 203 дугаар тогтоолоор баталсан⁶ төлөвлөгөөний "Орон нутгийн өмчит компани, аж ахуйн нэгжийн нэгдсэн мэдээллийн систем бий болгож, тэдгээрийн засаглалыг сайжруулах, хариуцлагын тогтолцоог бий болгох замаар аймаг, орон нутгийн эдийн засагт оруулах үр өгөөжийг нэмэгдүүлэх" зорилтыг Хөвсгөл аймгийн Засаг даргын 2021-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрт тусган дараах байдлаар хэрэгжилтийн тайлагнасан байна.

Хүснэгт №3

№	Хэрэгжүүлэх арга хэмжээний зорилт	Хэрэгжилтийн тайлан
"Орон нутгийн өмчит компани, аж ахуйн нэгжийн нэгдсэн мэдээллийн систем бий болгож, тэдгээрийн засаглалыг сайжруулах, хариуцлагын тогтолцоог бий болгох замаар аймаг, орон нутгийн эдийн засагт оруулах үр өгөөжийг нэмэгдүүлэх"		
1	217. Орон нутгийн өмчийн мэдээллийн баазад суурилсан өмчийн эзэмшил, ашиглалтын хариуцлагын тогтолцоог боловсронгуй болгох	Орон нутгийн өмчит 216 хуулийн этгээдийн удирдлагатай өмч эзэмшүүлэх гэрээг байгуулж, гэрээний биелэлтийг дүгнэн ажилласан.
2	219. Орон нутгийн өмчит болон өмчийн оролцоотой аж ахуйн нэгжүүдэд компанийн засаглалыг нэвтрүүлж, бүтээгдэхүүн үйлчилгээний үр өгөөжийг нэмэгдүүлэх	Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2021.12.30-ний өдрийн 115 тогтоолоор орон нутгийн өмчит "Хөвсгөл Ус Суваг" ХХК, "Хөвсгөл Эрчим Хүч" ХХК, "Шинэ Мөрөн худалдааны төв" ХК-ийн дүрмийг шинэчлэн боловсруулах ажлын хэсгийг байгуулсан. 2021 онд "Могойн гол" ХК-аас ногдол ашиг 91.0 сая төгрөгийг бүрэн төвлөрүүлэх боломжтой.

Хөтөлбөрийн хэрэгжилтийг дүгнэн үзэхэд Засгийн газрын болон аймгийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн зорилтын хэрэгжилт үр дүн багатай байна.

⁶ Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө

1.2.3. Аймгийн ИТХ-ийн шийдвэрээр иргэн аж ахуй нэгжийн хэрэгжүүлэх боломжтой үйл ажиллагаанд орон нутгийн өмчийн хуулийн этгээд байгуулсан байна.

АИТХ-ын 2021 оны 13 тогтоолоор шахмал түлж үйлдвэрлэл эрхлэх Эрчим илч түлш ХХК, АИТХ-ын 2022 оны 20 дугаар тогтоолоор зам засвар арчлалтын үйл ажиллагаа эрхлэх Шишхэд харгуй ХХК байгуулсан нь иргэн, аж ахуйн нэгжийн хэрэгжүүлж болох чиг үүргийг давхцуулсан байна.

Орон нутгийн өмчит Хөвсгөл эмийн эргэлтийн сан ХК нь 2019, 2020 онд үйл ажиллагаа алдагдалтай ажиллаж үр ашиггүй болсон тул компанийн ТУЗ-ын санал, аймгийн Засаг даргын саналыг үндэслэн аймгийн ИТХ-ын 2020 оны 12 дугаар сарын 03-ны өдрийн 08 дугаар тогтоолоор эд хөрөнгө, эд хөрөнгийн эрхийг уралдаант шалгаруулалтаар хувьчлах үндсэн чиглэлийн хэрэгжилтийг зохион байгуулах, компанийн эд хөрөнгө, эд хөрөнгийн эрхийн үнэлгээг батлах, уралдаант шалгаруулалтын дүнг баталгаажуулах, хувьцааны тоо, нэгж үнэ тогтоох эрхийг аймгийн ИТХТ-дэд шилжүүлсэн байна.

Хөвсгөл эмийн эргэлтийн сан ХК-ийн ТУЗ-ийн 2021 оны 13 дугаар тогтоолоор дуудлага худалдааны анхны үнийг 686.0 сая төгрөгөөр тогтоож, дуудлага худалдааны үр дүн 1,196.5 сая төгрөг болсон байна.

Хөвсгөл Эмийн эргэлтийн сан ХК-ийн эдийн засгийн гол үзүүлэлтийг хүснэгтээр харуулбал:

Хүснэгт №4

№	Үзүүлэлт	2019 он	2020 он	2021 он
1	Хөрөнгө	579,5	349,6	420,8
2	Өр төлбөр	552,7	552,7	615,9
3	Өмчийн дүн	26,7	-173,1	-195,0
4	Борлуулалтын орлого	1,428.1	1,062.1	606,6
5	Нийт зардал	1,438.8	1,208.8	789,5
6	Тайлант үеийн ашиг+, алдагдал-	-107.7	-146.7	-182,9

Хөвсгөл эмийн эргэлтийн сан ХК-ийн хөрөнгийн дуудлага худалдааны орлого 1,196.5 сая төгрөг болж 510.5 сая төгрөгийн дуудлага худалдааны орлого орон нутгийн орлогод төвлөрсөн байна.

Компаниудын ТУЗ нь цаг үеийн асуудал, бизнес төлөвлөгөөнд өөрчлөлт оруулах, хөрөнгө зарцуулах тухай шийдвэр гаргаж байгаа нь ТУЗ-ийн үйл ажиллагаа үр нөлөөгүй байна гэж үнэлэхээр байна.

ТУЗ-ын хурлын тэмдэглэлээс харахад гишүүд бодлогын асуудал хэлэлцэхгүй, компанийн засаглалын талаар мэдлэг дутмаг байгааг илэрхийлж, гишүүдийн мэргэшүүлэх, сургалт мэдээллээр хангах шаардлагатай байна.

БҮЛЭГ 2. Төрийн болон орон нутгийн өмчит, өмчийн оролцоотой хуулийн этгээдийн үйл ажиллагааны үр ашиг 2021 онд өссөн байна.

2.1.Төрийн болон орон нутгийн өмчит, өмчийн оролцоотой хуулийн этгээдийн зорилтот түвшнийг үндэслэлтэй төлөвлөж, хянаж батлаагүй байна.

2.1.1.Төрийн болон орон нутгийн өмчит, өмчийн оролцоотой хуулийн этгээдийн эдийн засгийн зорилтот түвшнийг үндэслэлтэй төлөвлөөгүй байна.

Хөвсгөл аймагт үйл ажиллагаа явуулж байгаа төрийн болон орон нутгийн өмчит, өмчийн оролцоотой хуулийн этгээдүүдийн гүйцэтгэх удирдлага эдийн засгийн


үзүүлэлт, зорилтот түвшнийг төлөвлөж, эрх бүхий байгууллагад хянуулахаар хүргүүлдэг.

Компаниуд эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшнийг орлого зардлын тайлангаар тооцож, мөнгөн гүйлгээний тайланг орхигдуулсан нь эдийн засгийн зорилтот түвшин биелэхгүй байх эрсдэлтэй байна.


Компанийн удирдлагууд эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшинд үйлдвэрлэлийн зардал, борлуулалт удирдлагын зардлыг тусад нь төлөвлөөгүй, эдийн засгийн тооцоо судалгаа дутуу, ихэвчлэн өмнөх жилийн гүйцэтгэлд суурилж, зардлыг зардлын төвөөр төлөвлөөгүй байна.

Компаниуд нь орох гарах мөнгөн урсгалыг үндэслэлтэй төлөвлөөгүйгээс төлөвлөсөн ажил, хөрөнгө оруулалтаа бүрэн хэрэгжүүлж чадахгүй байдалд хүрч байна.


Орон нутгийн өмчийн болон өмчийн оролцоотой хуулийн этгээдүүдийн 2019-2021 оны эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний төлөвлөгөө, гүйцэтгэлийг графикаар харуулбал:



Зорилтот түвшний 2019 оны борлуулалтын орлогын төлөвлөгөөний хэрэгжилтэд Могойн гол ХК-ийн борлуулалтын орлогын төлөвлөгөө 3,963.8 сая төгрөгөөр буурч, Хөвсгөл эрчим хүч ХХК-ийн орлогын төлөвлөгөө 172.8 сая төгрөгөөр давуулан биелүүлж материаллаг хэмжээгээр нөлөөлсөн байна.



Хуулийн этгээдүүдийн 2020 оны зорилтот түвшний хэрэгжилтээс нийт өглөг 13,068.7 сая төгрөгөөр хамгийн өндөр өөрчлөлт орсон байна. Энэ нь Хөвсгөл Ус суваг ХХК-ийн Азийн хөгжлийн банкны зээлээр хийсэн хөрөнгө оруулалтын 9,272.2 сая төгрөгийн урт хугацаатай зээлийн төлбөр нэмэгдсэнтэй холбоотой өсөж тайлагнасан



Хуулийн этгээдүүдийн 2021 оны зорилтот түвшний хэрэгжилтээс нийт өглөг 14,248.3 сая төгрөгөөр хамгийн өндөр дүнтэй байна. 2021 онд цахилгаан, ус, халаалтын зардлыг төрөөс хариуцан төлөхтэй холбоотой өр төлбөр нэмэгдсэн байна.

Компанийн удирдлагууд эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшинд авлага, өглөгийн түвшинг төлөвлөж батлаагүйгээс хэрэгжилтэд зөрүү өндөр дүнгээр гарч байна.

Хөвсгөл аймагт үйл ажиллагаа явуулж буй орон нутгийн өмчит, өмчийн оролцоотой хуулийн этгээдүүд нь жил бүрийн орлогын төлөвлөгөөг боловсруулан ТУЗ-өөр батлуулж ажиллаж байна.

Бусад компаниудын орлогын төлөвлөгөөний гүйцэтгэлийг хүснэгтээр харуулбал:

Хүснэгт №5

№	Хуулийн этгээдийн нэр	2019			2020			2021		
		Төл	Гүй	хувь	Төл	Гүй	хувь	Төл	Гүй	хувь
1	"Хөвсгөл Эрчим хүч" ХХК	10,358.9	10,495.4	101%	11,397.0	11,396.6	100%	11,992.4	12,710.3	106%
2	"Хөвсгөл Ус суваг" ХХК	1,698.0	1,698.0	100%	2,228.7	2,110.8	95%	2,283.7	2,372.5	104%
3	"Могойн гол" ХК	7,240.0	3,276.2	45%	5,019.1	2,577.1	51%	5,179.8	4,743.1	92%
4	Хот тохижилт үйлчилгээний төв ХХК	1,016.9	1,016.9	100%	920.5	920.5	100%	1,195.3	1,195.3	100%
5	"Хөвсгөл барилга захиалагчийн хяналтын төв" ОНӨААТҮГ				163.5	115.0	70%	278.9	278.9	100%
6	"Шинэ Мөрөн худалдааны төв" ХХК	315.0	317.2	101%	464.5	331.8	71%	453.7	506.2	112%
7	"Хөвсгөл эмийн эргэлтийн сан" ХХК	1,160.9	1,328.3	114%	1,622.2	1,060.5	65%	1,077.6	-	0%
Нийт		21,789.7	18,132.1	83%	21,815.6	18,512.2	85%	22,461.4	21,806.4	97%

Хүснэгтээс харахад Хөвсгөл барилга захиалагчийн хяналтын төв ОНӨААТҮГ, Шинэ Мөрөн Худалдааны төв ХХК-ийн орлогын төлөвлөгөө болон орлогын гүйцэтгэл 2020 оноос 2021 онд өссөн байна.

Хөвсгөл эрчим хүч ХХК, Хот тохижилт үйлчилгээний төв болон Хөвсгөл ус суваг ХХК-ийн хувьд орлогын төлөвлөгөө, гүйцэтгэлийн хэмжээ нь хүн амын суурьшил бүтээн байгуулалттай уялдан бага хэмжээгээр жил бүр тогтмол өсөн нэмэгдэж байна.

Сумын төвийн дулаан түгээх үйл ажиллагаа явуулдаг нэр бүхий 7 компани нь тухайн сумын төрийн болон төвийн шугамд холбогдсон бусад газруудаас халаалтын төлбөрийн орлогыг тогтоосон тарифын дагуу тогтмол төвлөрүүлэн ажиллаж байгаа хэдий ч бусад орлогын түвшинг нэмэгдүүлэхэд анхаарахгүй байна. Тухайлбал:

- Халуун усны орлого нэмэгдүүлэх, ашигтай ажиллахад өртөг тооцож, үнэ тарифтаа өөрчлөлт оруулаагүй
- Хог хаягдал тээвэрлэх, зайлуулах үйлчилгээний хэрэглэгчийн судалгаа тооцоолол байхгүй, өртөг тооцож, үнэ тарифтаа өөрчлөлт оруулаагүй
- Хэрэглээний цэвэр ус тээврийн өртөг тооцож, үнэ тарифтаа өөрчлөлт оруулаагүй

2.1.2. Орон нутгийн өмчийн газар орон нутгийн өмчит, өмчийн оролцоотой хуулийн этгээдийн эдийн засгийн зорилтот түвшнийг өмнөх жилүүдийн гүйцэтгэлд суурилан хянасан байна.

Орон нутгийн өмчит компанийн удирдлагууд төлөвлөсөн эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшнийг ТУЗ-аар хянуулалгүй Орон нутгийн өмчийн газарт хянуулж байгаа нь ТУЗ дээр асуудал үүсгэж, бизнес төлөвлөгөөг эдийн засгийн үзүүлэлт зорилтот түвшинд тусгасан орлого, зардлын дүнг өөрчилж байна.

Орон нутгийн өмчийн газар орон нутгийн өмчит, өмчийн оролцоотой хуулийн этгээдийн эдийн засгийн зорилтот түвшнийг өмнөх жилүүдийн гүйцэтгэлд суурилан хянасан байна.

Аудитад хамрагдагч компаниудаас Хөвсгөл АЗЗА ХК-ны гүйцэтгэх удирдлага компанийн эдийн засгийн үзүүлэлт зорилтот түвшнийг боловсруулж, ТУЗ-аар хэлэлцүүлж хянуулаад ТӨБЗГ-ын ажлын хэсгээр давхар хянуулж байгаа нь эдийн засгийн үзүүлэлт зорилтот түвшнийг хэрэгжих боломжтой үндэслэлтэй болгож байгаа сайн туршлага болж байна.

Хөвсгөл АЗЗА ХК-ийн эдийн засгийн үзүүлэлт зорилтот түвшнийг ТУЗ-ын түвшинд гол хяналт хэрэгжсэн байна.

2.1.3.Төрийн болон орон нутгийн өмчит, өмчийн оролцоотой хуулийн этгээдийн эдийн засгийн зорилтот түвшнийг хянаж, батлахад орон нутгийн өмчийн төлөөлөгч үүргээ үр дүнтэй хэрэгжүүлээгүй байна.

Орон нутгийн өмчийн газар нь орон нутгийн өмчит, өмчийн оролцоотой хуулийн этгээдүүдийн эдийн засгийн үзүүлэлт зорилтот түвшнийг хянаад Хөвсгөл аймгийн ИТХ-аар хянуулан баталгаажуулж байна.

Хөвсгөл АЗЗА ХК-ийн эдийн засгийн үзүүлэлт зорилтот түвшнийг Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар хянаж тогтоол гарган баталгаажуулсан байна.

Могойн гол ХК-ийн төрийг төлөөлөх ТУЗ-ын зарим гишүүд 2021 оны ноогдол ашиг олголтыг хойшлуулах, шинээр дэд захирлын орон тоог бий болгох, ТУЗ-ын зардлыг нэмэгдүүлэх, коксжих нүүрсний үнийг зах зээлийн таатай нөхцөлтэй уялдуулан бодитой тогтоох асуудалд 51 хувийн хувьцаа эзэмшигч болох ИХТ-ын санал, удирдамжийг зөрчсөн, компанийн эрх ашигтай нийцэхгүй саналыг дэмжиж ажилласан байна.

Энэ нь Компанийн тухай хуулийн 84 дүгээр зүйл "Компанийн эрх бүхий албан тушаалтан 84.4.2. “үйл ажиллагаандаа компанийн эрх ашгийг дээдлэх зарчмыг баримталж, энэ хууль болон компанийн дүрмээр тогтоосон үүргээ чанд биелүүлэх”; 84.4.3."Компанийн эрх ашигт нийцүүлэн үндэслэлтэй шийдвэр гаргах", Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 21.6 "Төрийн өмчийн төлөөлөгч болон

төлөөлөн удирдах зөвлөлийн төрийг төлөөлөх гишүүнээр томилогдсон этгээд нь төрийн мэдлийн хувьцаа эзэмшигчээс баталсан удирдамж, зааврыг баримтлан ажиллана, Удирдамж, зааврыг зөрчсөн буюу зохих ёсоор биелүүлээгүй нь түүнийг томилсон шийдвэрийг хүчингүй болгох үндэслэл болно” заалтай нийцэхгүй байна.

Орон нутгийн өмчийн 51 хувийн оролцоотой Могойн гол ХК-ийн эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшнийг Хөвсгөл аймгийн ИТХ-аар баталж байгаа нь Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлд заасан хувьцаа эзэмшигчдийн бүрэн эрхтэй нийцэхгүй байна.

2.2.Төрийн болон орон нутгийн өмчит, өмчийн оролцоотой хуулийн этгээдийн орлого бүрдүүлэлт зорилтот түвшиндээ хүрээгүй байна.

2.2.1.Төрийн болон орон нутгийн өмчит, өмчийн оролцоотой хуулийн этгээдийн орлогын төлөвлөгөө бүрэн биелээгүй байна.

Орон нутгийн өмчит болон өмчийн оролцоотой хуулийн этгээдүүдийн 2019-2021 онуудад дараах орлого бүрдүүлэн ажилласан байна. Хүснэгтээр харуулбал:

Хүснэгт №6

№	Үзүүлэлт	2019 он		2020 он		2021 он	
		төл	гүйц	төл	гүйц	төл	гүйц
1	Нийт борлуулалтын орлого	23,178.1	20,789.5	24,270.6	21,715.3	25,630.6	25,587.1
2	Үндсэн орлого	21,200.7	18,567.3	22,033.9	20,044.4	23,593.9	24,843.3
3	Бусад орлого	1,977.5	2,222.2	2,236.6	1,670.8	2,036.6	743.8

Нийт борлуулалтын орлогын төлөвлөгөө 2019, 2020, 2021 онуудад бүрэн биелээгүй тасарсан байна.

Үндсэн үйл ажиллагааны орлого 2019, 2020 онд тасарч 2021 онд 1,294.4 сая төгрөгөөр давж биелсэн байна. Орлого тасрахад Ковид 19 цар тахал гарсантай холбоотой компаниудын үйл ажиллагаа зарим тохиолдолд хаагдаж, доголдсоноос шалтгаалсан байна.

Могойн гол ХК нь өнөөгийн байдлаар Хятад улсын зах зээлд 1 тонн коксжих нүүрсний үнэ дунджаар 2,000 юаньд хүрээд байгаа ба энэ нь өмнөх оноос бараг 3 дахин өссөн үзүүлэлт ба 2022 онд үнэ тогтвортой хадгалагдах прогнозтой байна. Бизнес төлөвлөгөөнд коксжих 1 тонн нүүрсний үнийг 60,000 /НӨАТ-гүй/ төгрөгөөр тогтоосон нь зах зээлийн нөхцөл байдалд тулгуурлан бодитой тогтоож чадаагүй байна.

Сумын халаалтын үйл ажиллагаа эрхэлдэг Галт дулаан ХХК, Тэсийн илч ХХК, Шинэ идэр дулаан илч ХХК, Тосон илч ХХК, Их уул илч ХХК, Тариалан НААҮТ ХХК, Түнэл илч ХХК-иудийн хог хаягдал зайлуулах үйл ажиллагааны чиглэлийн орлогыг сумын орон нутгийн орлогод хуваарилагдсанаас орлогыг бүрэн оруулах, нэмэгдүүлэх талаар санаачилгагүй төсвөөс хуваарилсан хог хаягдлын төлбөрийн орлогыг л хүлээн авч байна.

Компаниуд нь улс орон нутгийн төсвийн хөрөнгөөр хийгдсэн тоног төхөөрөмж, багаж хэрэгсэл, хандив тусламжаар нийлүүлсэн хөрөнгийг бүртгэж тайлагнахдаа харилцан адилгүй бүртгэж тайлагнаж байна. Тухайлбал: Орон нутгийн өмчит үйлдвэрийн газрууд үнэ төлбөргүйгээр олж авсан үндсэн хөрөнгийг капиталын аргаар, орлогын аргаар хольж бүртгэж байсантай холбоотойгоор санхүүгийн тайланд үйл ажиллагааны орлого бүртгэж татвар өндөр хэмжээгээр 1 жилд төлөх, хуримтлагдсан алдагдал өсөх зэргээр голлон нөлөөлжээ.

Иймд аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18.24 -т заасны дагуу боловсруулах, орон нутгийн өмчит үйлдвэрийн газрууд үнэ төлбөргүйгээр үндсэн хөрөнгө олж бэлтгэсэн тохиолдолд бүртгэлийн аль аргыг хэрэглэхийг уг бодлогын баримт бичигт нарийвчлан тусгах шаардлагатай байна.

Шинэ Мөрөн Худалдааны Төв ХХК нь тус байгууллагын эзэмшилд байдаг газарт худалдаа эрхлэгчдэд өөрсдийн хөрөнгөөр барилга байгууламж барьж худалдаа эрхлэх зөвшөөрөл олгосон байна. Ингэхдээ тухайн худалдаа эрхлэгчидтэй газрын эзэмших эрх, бусад тулгарч болох асуудлуудыг хэрхэн зохицуулах талаар ямар нэгэн гэрээ хэлцлийг байгуулаагүй нь цаашид газар эзэмших эрх болон хөрөнгийн маргаан үүсэх эрсдэлийг үүсгэж байна.

2.2.2. Улс, орон нутгийн төсөвт төвлөрүүлэх татвар, төлбөр, хураамжийг бүрэн төвлөрүүлэлт 2021 онд өссөн байна.

Хөвсгөл аймгийн орон нутгийн өмчит, өмчийн оролцоотой хуулийн этгээдийн 2020, 2021 оны татварын мэдээллийг хүснэгтээр харуулбал: *Хүснэгт №7*

Татвар	2020 он		2021 он	
	Төлсөн татвар	Татварын өр	Төлсөн татвар	Татварын өр
ААНОАТ	296.0	6.4	252.9	65.9
ХХОАТ	385.4	72.8	302.0	32.6
НӨАТ	696.7	81.7	1,041.9	480.3

Аж ахуйн нэгжийн орлогын албан татварт 2020 онд 7 компани 296.0 сая төгрөг, 2021 онд 11 компани 252.9 сая төгрөг төлсөн байна.

ХХОАТ-ыг үйл ажиллагаа явуулж буй бүх компани ажилчдаас суутган төлж байгаа бөгөөд 2020 онд 385.4 сая төгрөг, 2021 онд 302.0 сая төгрөг нийт 675.1 сая төгрөгийг суутган төлж 2021 оны байдлаар 32.6 сая төгрөгийн өртэй байна.

НӨАТ-ын өр төлбөр 2020 онд 81.7 сая төгрөг, 2021 онд 480.3 сая төгрөг болж өмнөх оноос 398.6 төгрөгөөр өссөн байна. НӨАТ-ын төлөлт 2021 онд 1,041,9 сая төгрөг болсон нь компаниудын үйл ажиллагаа, борлуулалт өссөнтэй холбоотой байна.

Дээрх татваруудаас гадна байгалийн нөөц ашигласан болон үйл ажиллагааны чиглэлд хамаарах төлбөр хураамжийг тогтоосон үнэ тарифын дагуу төлж байна.

Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газар нь 2021 онд Хөвсгөл ус суваг ХХК-ийн үйл ажиллагаанд гүйцэтгэлийн аудитаар ус ашигласны төлбөрийг төлөөгүй байсан 2.2 сая төгрөгийн зөрчил илрүүлж акт тогтоон орон нутгийн төсөвт төвлөрүүлсэн байна.

Могойн гол ХК-ийн улс, орон нутгийн төсөвт 2021 онд төлөх нэмэгдсэн өртгийн албан татвар 198.5 сая төгрөг, нүүрсний агаарын бохирдлын төлбөр 84.5 сая төгрөг, аж ахуйн нэгжийн орлогын албан татвар 76.7 сая төгрөг, ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр 46.2 сая төгрөг нийт 405.9 сая төгрөгийг Хөвсгөл аймгийн Татварын хэлтсийн хүсэлтээр хойшлуулж 2022 онд төлсөн байна. Энэ нь Татварын ерөнхий хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2 "Татварын тайлан тушаах, татвар төлөх хугацааг тухайн төрлийн татварын хуулиар тогтоох бөгөөд хуульд өөрөөр заагаагүй бол татвар төлөх, тайлагнах хугацаа адил байна" заалттай нийцэхгүй байгаа ба компанийн эдийн засгийн үзүүлэлтэд сөргөөр нөлөөлсөн байна.

2.3. Төрийн болон орон нутгийн өмчит, өмчийн оролцоотой хуулийн этгээдийн үйл ажиллагаа зорилт түвшнийг хангаж, үр ашиг нэмэгдсэн байна.

2.3.1. Аймгийн орон нутгийн өмчийн газраас компаниудын санхүүгийн үйл ажиллагаанд үр ашгийн тооцоо, шинжилгээ хийж удирдах дээд байгууллагадаа танилцуулан үр дүнг тооцон ажилласан байна.

Орон нутгийн өмчийн хуулийн этгээдийн санхүүгийн үр дүнг сүүлийн 3 жилээр авч үзэхэд 2019 онд 8 хуулийн этгээд 732.2 сая төгрөгийн ашигтай, 11 хуулийн этгээд 595.1 сая төгрөгийн алдагдалтай, 2020 онд 10 хуулийн этгээд 1,014.2 сая төгрөгийн ашигтай, 9 хуулийн этгээд 831.5 сая төгрөгийн алдагдалтай, 2021 онд 12 хуулийн этгээд 2,018.6 сая төгрөгийн ашигтай, 5 хуулийн этгээд 307.9 сая төгрөгийн алдагдалтай ажилласан байна.

Хүснэгт №8

№	Хуулийн этгээдийн нэр	2019 он	2020 он	2021 он
1	"Могойн гол" ХК	673.2	96.8	796.0
2	"Хөвсгөлийн эмийн эргэлтийн сан" ХХК	-107.7	146.7	182.9
3	"Хөвсгөл Эрчим хүч" ХХК	7.0	194.4	490.8
4	"Хөвсгөл Ус суваг" ХХК	6.5	14.5	111.5
5	"Шинэ Мөрөн худалдааны төв" ХХК	-132.8	-243.4	-145.8
6	Их-Уул сумын "Их-Уул Дулаан" ХХК	-40.1	-32.9	1.0
7	Тариалан сумын "Нийтийн ахуй үйлчилгээний төв" ХХК	9.6	16.7	10.5
8	Тосонцэнгэл сумын Тосон-Илч ХХК	2.9	91.1	107.4
9	Түнэл сумын "Түнэл-Илч" ХХК	19.8	56.1	-55.9
10	Цагаан-Уул сумын "Галт дулаан" ХХК	-16.9	342.2	158.1
12	"Мөрөн хот тохижилт үйлчилгээний төв" ХХК		-377.7	
13	"Тэсийн-Илч" ХХК	-171.7	-128.5	-148.6
14	"Шинэ-Идэр Дулаан Эрдэнэт" ХХК	-30.6	38.0	36.2
15	"Дүгийн Эх" ОНӨААТҮГ	-62.2		-3.8
16	"Урандөш зуслан" ОНӨҮГазар	12.7	-24.6	0.2
17	"Эрчимт-Идэр" СДОА	-6.0	-12.5	-4.1
18	"Дэлгэрмөрөн" СДОА	-1.8	-3.9	3.4
19	"Баян шишгэд" СДОАнги	-20.9	0.0	0.0
20	"Нарс шинэсэн төгөл" СДОА	-4.4	-4.4	19.5
21	"Хөвсгөл барилга захиалагчийн хяналтын төв" ОНӨААТҮГ		17.7	101.1
22	"Мөнххаан савдаг" ОНӨААТҮГ		-3.6	-5.6
23	"Хатгал цахир" ОНӨҮГ	0.5	-3.4	5.6

Орон нутгийн өмчийн оролцоотой Могойн гол ХК, Төрийн өмчийн Хөвсгөл АЗЗА ТӨХК, Хөвсгөл эрчим хүч ХХК, Хөвсгөл Ус суваг ХХК-ийн гүйцэтгэх удирдлагаас үйл ажиллагааны зорилтот түвшний хэрэгжилт, санхүүгийн үзүүлэлтэд шинжилгээ хийж ТУЗ болон АИТХ-д танилцуулж үр нөлөө, үр дүнгээ тооцон ажилласан байна.

Аймгийн орон нутгийн өмчийн газраас орон нутгийн өмчийн болон өмчийн оролцоотой компаниудын санхүүгийн үйл ажиллагааны үр дүнд шинжилгээ хийж үр дүнг АИТХ-д танилцуулж ажилласан байна. Тухайлбал:

- Хөвсгөл Эмийн эргэлтийн сан ХК-ийн 2019, 2020 онуудын санхүүгийн шинжилгээ, эдийн засгийн үзүүлэлтүүд хангалтгүй байгааг танилцуулан шаардлагатай арга хэмжээг авч хэрэгжүүлсэн байна.
- Хоймор нутгийн чулуу ХХК-ийн санхүүгийн үйл ажиллагааны үр дүнд хийсэн шинжилгээний үр дүнгээр татан буулгах шийдвэр гаргасан байна.

2.3.2 Галт дулаан ХХК-ийн их хэмжээний хэлцлийг үр ашиггүй, хууль зөрчиж хийсэн байна.

Цагаан-Уул сумын ИТХ-ийн зөвшөөрснөөр Галт дулаан ХХК нь Идэр нумт ХХК-тай дулааны шугам шинэчлэх төслийн ажилд төр хувийн хэвшлийн түншлэлийн гэрээгээр 2019 онд 1,980.0 сая төгрөгийн их хэмжээний хэлцэл хийж, хэлцлийг

сумын засаг дарга Т.Түмэнбаяр баталгаажуулсан нь Компанийн тухай хуулийн 83 дугаар зүйлийн 83.8⁷ дах хэсгийг зөрчсөн байна.

Уг их хэмжээний хэлцлийн гэрээт ажил 2019 оны 10 дугаар сард гүйцэтгэж дууссаны даруу буюу 2019 оны 11 дүгээр сарын 05-ны өдөр гэрээний дүн 1,889.9 сая төгрөгөөр, жилийн 10 хувийн хүүтэй /1,098.5 сая төгрөг/ нийт 2,988.4 сая төгрөгөөр, дахин гэрээнд өөрчлөлт оруулан 2020 оны 11 сарын 04-ний өдөр 1,453.6 сая төгрөг болгон өөрчлөлт оруулсан байна.

Гэрээнд төлбөрийн хүү тооцох тухай заагаагүй байхад гэрээний хавсралтад гэрээний үнийн дүнгээс жил бүр 10 хувийн хүү тооцон үндсэн төлбөрийн хамт 6 жилийн хугацаанд төлөхөөр заасан нь компанийн хувьд жилийн орлогоороо ч төлж чадахгүй үр ашиггүй гэрээ болсон байна.

Гэрээнд заасан төлбөрийг хугацаандаа төлөөгүйгээс гүйцэтгэгч Идэр нумт ХХК нь сум дундын шүүхэд гомдол гарган одоогийн байдлаар шүүхийн шийдвэр гараагүй, шүүхийн шатанд маргаантай байна.

Цагаан уул суманд төр хувийн хэвшлийн түншлэлээр их хэмжээний хэлцлийн гэрээгээр гүйцэтгэсэн дулааны шугамын худалдан авах ажиллагааны баримтыг аймгийн Орон нутгийн өмчийн газраас аудитын хугацаанд ирүүлээгүй тул Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.4⁸ дэх хэсэг, 16 дугаар зүйлийн 16.1.4⁹ заалтыг зөрчиж байна.

Цагаан уул сумын иргэдийн төлөөлөгчдийн хурлаас дээрх их хэмжээний хэлцэл, төр хувийн хэвшлийн түншлэлээр гүйцэтгэсэн дулааны шугамын ажлын өртөг, гүйцэтгэл нь үр ашиггүй гэж үнэлж дүгнэсэн байна.

Гүйцэтгэгчийн гүйцэтгэлийн төсөвт гүйцэтгээгүй 0.4 кв-ын кабель шугамын ажил, 10 кв-ын агаарын кабель шугамын ажил, КТПН-250 ква төхөөрөмжийн ажил 49.6 сая төгрөг, 1 ш тогооны үнэ 32.2 сая төгрөг, уурын зуухны барилгын засварын ажил хийгээгүй, ажиллах хүч, техникийн ашиглалтын зардлыг баталгаажсан төсөв, ажлын гүйцэтгэлтэй зөрүүтэйгээр гаргасан нь ЗД-ын захирамжаар томилогдсон ажлын хэсгийн дүгнэлтэд тусгагдсан байна.

Цагаан уул сумын дулааны шугам шинэчлэх төслийн ажлыг хүлээж авах улсын комисс үр дүнгүй ажилласнаас дээрх маргаан үүссэн, төслийн ажилд техникийн болон зохиогчийн хяналт хийгээгүй, улсын комисс зөрчил аргасан эсэхэд хяналт хийгээгүй, зөрчил арилаагүй байна. Иймд уг төслийн Барилгын тухай хуулийн 14.3, 14.5, 14.6¹⁰-д заасан баталгаанд улсын комиссыг дахин ажиллуулах буюу мэргэжлийн комисс ажиллуулж хэмжилт хийж, зураг төсвийн дагуу хийгдсэн эсэхэд дүгнэлт гаргуулах албан шаардлагыг АЗДТГ-ын хөгжлийн бодлогын хэлтсийн дарга Б.Оюунтуяа-д хүргүүлж байна.

2.4.Төрийн болон орон нутгийн өмчит, өмчийн оролцоотой хуулийн этгээдийн санхүүгийн үйл ажиллагаа зардал үр ашгийн зохистой харьцаа хангагдаж байна.

⁷ 83.8.Гүйцэтгэх удирдлага нь төлөөлөн удирдах зөвлөлөөс олгосон эрх хэмжээний хүрээнд хэлцэл хийх, гэрээ байгуулах, компанийг төлөөлөх зэргээр компанийн нэрийн өмнөөс итгэмжлэлгүйгээр үйл ажиллагаа явуулна.

⁸ 15.4.Энэ хуулийн 15.2-т заасан чиг үүргээ хэрэгжүүлэхэд саад учруулах, аудитад шаардлагатай мэдээлэл, баримт бичгийг нуун дарагдуулахыг хориглоно.

⁹ 16.1.4.төрийн аудитын байгууллагаас тогтоосон хугацаанд шаардсан мэдээлэл, баримт бичгийг бүрэн ирүүлэх;

¹⁰ 14.6.Энэ хуулийн 14.3-т заасан хугацаа дуусгавар болсноос хойш барилга байгууламжийн гадна, дотор засал, бүх төрлийн материал, үндсэн хийц, бүтээц, цэвэр, бохир ус, уур, хий, дулаан, цахилгаан, харилцаа холбооны тоног төхөөрөмж, тоноглолын хэвийн ашиглалтын хугацаа гурваас доошгүй жил байна.

2.4.1. Удирдлагын зардлыг оновчтой төлөвлөөгүйгээс үр ашиггүй зардал гарсан байна.

Орон нутгийн өмчийн болон өмчийн оролцоотой хуулийн этгээдийн удирдлагын зардлын төлөвлөлт, гүйцэтгэлд хийсэн судалгааг хүснэгтээр харуулбал:

Хүснэгт №9

№	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Хэмнэлт +, хэтрэлт-
1	2019 он	1,023.0	1,896.4	-873.40
2	2020 он	1,736.5	1,599.7	136.80
3	2021 он	1,916.8	2,014.4	-97.60

Хүснэгтээс харахад удирдлагын зардал 2019 онд 873.4 сая төгрөг, 2021 онд 97.6 сая төгрөг хэтрүүлсэн, 2020 онд 136.8 сая төгрөгөөр хэмнэсэн байна.

Компаниудын удирдлагын зардал нь тайлант оны нийт зардлын 10 орчим хувийн эзэлж, ихэнх хуулийн этгээдүүд удирдлагын зардлыг төлөвлөж, бүртгээгүй байна.

Компанийн удирдлагын зардлыг үр ашиггүй зарцуулагдсан байна. Тухайлбал:

- Хөвсгөл эрчим хүч ХХК-ийн гүйцэтгэх захирал Г.Очирхуягт Гүйцэтгэх захиралтай байгуулсан гэрээний 4.3.1-д компанийн санхүү, үйл ажиллагаа, эдийн засгийн үзүүлэлтүүдийн зорилтот түвшин гэрээний үүрэг 100 хувь биелсэн тохиолдол компанийн тухайн жилийн үйл ажиллагааны цэвэр ашгаас 10 хүртэл хувийг гүйцэтгэх захиралд 1 удаа урамшуулал болгон олгоно гэсэн байна. Энэ нь Эрчим хүч ХХК нь 2019 оны зорилтот түвшний үзүүлэлт бүрэн биелээгүй авлага 3.6 дахин өссөн, өглөг 2.1 дахин өссөн байх гүйцэтгэх захирал Г.Очирхуягт 7.8 сая төгрөгийн урамшуулал олгосон байна.
- ТУЗ-ийн 2019 оны 10 дугаар сарын 18 дугаар тогтоолоор ХБНГУ-ын Барут хотод Хөвсгөл аймгийн иргэдийг найдвартай эрчим хүчээр хангах, шинэ технологи, ухаалаг системийг нэвтрүүлэх эдийн засгийн үр ашиг, санхүүгийн талаар судлах хамтран ажиллах зорилгоор компанийн ерөнхий нягтлан А.Бүдсүрэн томилолтын зардалд 10.0 сая төгрөг зарцуулсан нь компанийн удирдлагын зардлыг нэмэгдүүлж, томилолтын үр дүн, үр нөлөө гараагүй байна
- Хөвсгөл эрчим хүч ХХК-ийн ТУЗ-ийн 2019 оны 10 дугаар сарын 12 дугаар тогтоолоор Турк улсад ТУЗ-ийн гишүүдийн туршлага судлахад 44.0 сая төгрөгийн гадаад томилолтод зарцуулсан нь компанийн удирдлагын зардлыг нэмэгдүүлж, томилолтын үр дүн, үр нөлөө гараагүй байна.
- Могойн гол ХК, Эмч нарыг дэмжигч төрийн бус байгууллагатай Могойн гол ХК-ийн ажилчдыг нарийн мэргэжлийн эмчийн өвчнийг эрт илрүүлэх урьдчилан сэргийлэх үзлэг оношилгоонд хамруулан эмчлэн эрүүлжүүлэх зорилгоор түншлэлийн 2 жилийн гэрээ байгуулж, ТУЗ-д танилцуулаагүй 2022 оны 5 дугаар сарын 3-ны өдөр 30.0 сая төгрөг шилжүүлсэн байна. Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1 "Захирал дараах эрх, үүрэгтэй:... 3/үйлдвэрийн газрын үйлдвэрлэл, санхүүгийн төлөвлөгөө боловсруулж, зохих байгууллагаар батлуулан биелэлтийг хангах..." заалттай нийцэхгүй байна.
- Хөвсгөл аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2 дугаар сарын 21-ний өдрийн 01/76 тогтоол, Могойн гол ХК-ийн ТУЗ-ийн 2022 оны 02 дугаар сарын 22-ны өдрийн 8 дугаар тогтоолын дагуу Хөвсгөл аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын нэмэлт санхүүжилтийн дансанд 20.0 сая төгрөг шилжүүлэн үр ашиггүй

зардал гаргасан байна. Хөвсгөл аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2 дугаар сарын 21-ний өдрийн 01/76 тогтоолын дагуу "Монгол Улсын Үндсэн хууль батлагдсаны 30 жилийн ойн арга хэмжээнд зарцуулахаар хөрөнгө зарцуулсан нь Төсвийн тухай хуулийн 25.10."Төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээд хандив, тусламж өгөхийг хориглоно" заалттай нийцэхгүй байна.

- Могойн гол ХК-ийн бизнес төлөвлөгөөнд ТУЗ-ийн гадаадад томилолтоор явах зардал гэж 2021 онд 50.0 сая төгрөгийг компанид үр ашиггүй зардал баталсан байна. Дээрх зөрчлүүд нь Компанийн тухай хуулийн 84 дүгээр зүйл "Компанийн эрх бүхий албан тушаалтан 84.4.2.үйл ажиллагаандаа компанийн эрх ашгийг дээдлэх зарчмыг баримталж, энэ хууль болон компанийн дүрмээр тогтоосон үүргээ чанд биелүүлэх; 84.4.3.компанийн эрх ашигт нийцүүлэн үндэслэлтэй шийдвэр гаргах" заалтуудтай нийцэхгүй нийцэхгүй байна.

2.4.2.Үйл ажиллагааны зардлыг төлөвлөснөөс хэмнэлттэй ажилласан байна.

Төрийн болон орон нутгийн өмчийн хуулийн этгээдүүдийн сүүлийн 3 жилийн нийт зардлын төлөвлөлт гүйцэтгэл дараах байдалтай байна. *Хүснэгт №10*

Үзүүлэлт	2019 он		2020 он		2021 он	
	Баталсан	Тайлаг насан	Баталсан	Тайлаг насан	Баталсан	Тайлаг насан
1 Төрийн өмчит ХК	1,247.6	1,356.8	1,362.8	1,957.8	2,736.6	1,985.0
2 Орон нутгийн өмчийн болон оролцоотой хуулийн этгээд	21,211.4	19,004.8	23,094.2	20,362.6	24,534.7	24,205.9

Орон нутгийн өмчийн болон оролцоотой хуулийн этгээдийн нийт зардал төлөвлөснөөс хэмнэлттэй, харин төрийн өмчийн Хөвсгөл АЗЗА ТӨХК-ийн нийт зардал зорилтот түвшнээс 2019 онд 109.2 сая төгрөгөөр, 2020 онд 595.0 сая төгрөгөөр хэтэрч 2021 онд 751.6 сая төгрөгөөр хэмнэсэн байна.

Хөвсгөл АЗЗА ТӨХК-ийн 2020 оны нийт зардлын түвшин төлөвлөснөөс хэтэрсэн нь төлөвлөөгүй Тариалан сумын авто замын ажлыг гүйцэтгэсэнтэй холбоотойгоор материал, цалингийн зардал гарсан байна.

Батлагдсан орон тоонд нийцүүлэн цалин урамшуулал олгосон байна.

Орон тоо, цалингийн сангийн судалгааны нэгтгэл

Хүснэгт №11

Үзүүлэлт	2019 он			2020 он			2021 он		
	Ор он тоо	Цалингийн сан	Дундаж цалин	Ор он тоо	Цалингийн сан	Дундаж цалин	Ор он тоо	Цалингийн сан	Дундаж цалин
Төрийн өмчит ХК	45	407.1	9.0	46	575.8	12.5	41	534.9	13.0
Орон нутгийн өмчийн болон оролцоотой хуулийн этгээд	598	5,079.9	8.5	596	5,331.6	8.9	593	5,685.6	9.6

Төрийн болон орон нутгийн өмчийн хуулийн этгээдүүд зорилтот түвшинд батлагдсан орон тоонд багтаан ажилласан байна.

Судалгаанаас харахад 1 ажилтанд ногдох цалин 2019 онд 8.5 сая төгрөг, 2020 онд 8.9 сая төгрөг, 2021 онд 9.6 сая төгрөг болж өссөн байна.

Тайлант 2021 онд Могойн гол ХК, Галт дулаан ХХК, Эрчим хүч ХХК ажилтны цалин хөлсийг нэмэгдүүлсэн нь Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоол “Төсвийн

хэмнэлтийн талаар авах зарим арга хэмжээний тухай”-ын 1.3¹¹ заалтыг зөрчсөн байна.

Могойн гол ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн хурлаар ТУЗ-ын зардал, ТУЗ-ын гишүүдийн цалингийн хязгаарыг ажлын ачаалал үр дүнг харгалзан олгох байдлаар тогтоож өгөөгүй байна. Тухайлбал ТУЗ-ын 2021 оны 5 дугаар сарын 21 -ний өдрийн 02 тоот тогтоолоор 2021 оны зардлын төсвийн батлахдаа ТУЗ-ийн гишүүний урамшууллыг сард 400 мянган төгрөг байсныг 800 мянган төгрөг болгож нэмэгдүүлсэн нь Засгийн газрын 2021 оны 2 дугаар сарын 17-ны өдрийн 43 дугаар тогтоолын 1.3-т заасан удирдлагын цалин хөлсийг орлого, үр ашигтай нь уялдуулан, үйл ажиллагааны чиглэл, цар хүрээ, түвшин зэргийг харгалзан нэг хэлбэр, нийтлэг жишгээр ангилан тогтоодог зарчимд шилжих, цалин хөлсийг нэмэгдүүлэхгүй байх заалттай нийцэхгүй байна. Мөн Могойн гол ХК-ын ТУЗ-ын гишүүдэд 2022 онд 1 сая 200 мянган төгрөгийн цалин олгох шийдвэр гаргасан орон нутгийн өмчит компаниудын ТУЗ-ын гишүүдийн урамшууллаас 6 дахин их тогтоосон нь удирдлагын зардлыг өсгөж компанийн үйл ажиллагааны үр ашгийг бууруулж байна.

Үйл ажиллагааны зардлыг үр ашиггүй, үр дүнгүй зарцуулсан дараах зөрчил илэрсэн. Үүнд:

- Эрчим хүч ХХК нь жил бүр салбарын тэргүүний ажилтны цол тэмдгийн урамшуулалд 10.0 сая төгрөг зарцуулж байгаа нь Эрчим хүчний Сайдын 2016 оны 97 дугаар тушаалаар баталсан “Эрчим хүчний салбарын шагнал олгох журам” –ын 1 дүгээр хавсралтын 5.3 заалтыг зөрчиж байна.
- Аймгийн ИТХТ-ын 2019 оны 47 дугаар тогтоолоор замын хөдөлгөөний хяналтын постын цахилгааны эх үүсвэрийг шийдвэрлэхэд 10.0 сая төгрөг, аймгийн эх хүүхэд нөхөн үржихүйн эрүүл мэнд хөтөлбөрт 4.0 сая төгрөг, сүрьеэгийн илрүүлэг үзлэгт 2.0 сая төгрөг, бэлгийн замаар дамжих халдварт өвчин илрүүлэхэд 5.0 сая төгрөг нийт 11.0 сая төгрөгийг аймгийн ЭМГ-т шилжүүлсэн. хэрэгжилтийн тайлан, үр дүн, баримтын бүрдэлгүй, компанийн үйл ажиллагааны чиглэл бус үйл ажиллагаанд хөрөнгийг үр ашиггүй зарцуулсан. Төсвийн тухай хуулийн 25.10.Төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээд хандив, тусламж өгөхийг хориглоно. Заалтыг зөрчсөн байна.
- Гүйцэтгэх захирлын 2021 оны А/92 тушаалаар Компанийн 55 жилийн ойн болон эрчим хүчний ажилтны өдрийг тэмдэглэхэд 20.0 сая төгрөг зарцуулсан нь ЗГ-ын 2021 оны 43 дугаар тогтоол “Төсвийн хэмнэлтийн талаар авах зарим арга хэмжээний тухай”-ын 1.6. Засгийн газрын шийдвэр гарснаас бусад баяр ёслол, тэмдэглэлт ой, урлагийн наадам, спортын уралдаан тэмцээн, салбарын өдөр, аялал зугаалга зэргийг зохион байгуулахгүй байх; заалтыг зөрчсөн байна
- Аймгийн ИТХТ-ын 2019 оны 47 дугаар тогтоолоор Нэгдсэн эмнэлгийн цахилгаан хангамжийн хаалттай дэд өртөө, шугам сүлжээг засварлах, өргөтгөх ажилд 152.0 сая төгрөг зарцуулсан нь компанийн хөрөнгийн үр ашиггүй зарцуулсан, аймгийн орон нутгийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэхээр шийдвэрлүүлээгүй байна. Цахилгааны үнэ тарифын өөрчлөлтөөр нэрийдлээр компанийн хөрөнгийг үр ашиггүй зарцуулж байна.
- Аймгийн ИТХТ-ын 2019 оны 47 дугаар тогтоолоор замын хөдөлгөөний хяналтын постын цахилгааны эх үүсвэрийг шийдвэрлэхэд 10.0 сая төгрөг,

¹¹ 1.3. төрийн болон орон нутгийн өмчит, тэдгээрийн оролцоотой аж ахуйн нэгж, ..., цалин хөлсийг нэмэгдүүлэхгүй, шагнал, урамшуулал олгохгүй байх, зочин төлөөлөгч хүлээн авах, бэлэг дурсгал (цүнх, календарь, мэндчилгээ г.м)-ын зардлыг гаргахгүй байх;

аймгийн эх хүүхэд нөхөн үржихүйн эрүүл мэнд хөтөлбөрт 4.0 сая төгрөг, сүрьеэгийн илрүүлэг үзлэгт 2.0 сая төгрөг, бэлгийн замаар дамжих халдварт өвчин илрүүлэхэд 5.0 сая төгрөг нийт 11.0 сая төгрөгийг аймагийн ЭМГ-т шилжүүлсэн. хэрэгжилтийн тайлан, үр дүн, баримтын бүрдэлгүй, компанийн үйл ажиллагааны чиглэл бус үйл ажиллагаанд хөрөнгийг үр ашиггүй зарцуулсан. Төсвийн тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.10.Төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээд хандив, тусламж өгөхийг хориглоно” заалтыг зөрчсөн байна.

- ТУЗ-ийн 2020 оны 22 дугаар тогтоолоор 10.0 сая төгрөгийг АИТХ-ын тавилга, эд хогшил авахад зарцуулсан нь Төсвийн тухай хуулийн 25.10.Төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээд хандив, тусламж өгөхийг хориглоно. Заалтыг зөрчсөн байна.
- ТУЗ-ийн 2019 оны 09 тогтоолоор тариалан ЕБС 5.0 сая, Алаг эрдэнэ ЕБС - 5.0 сая, Нийтийн номын сангийн газарт 4.5 сая ойн хандив тусламжид хөрөнгө зарцуулсан нь Төсвийн тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.10.”Төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээд хандив, тусламж өгөхийг хориглоно” заалтыг зөрчсөн байна.
- ТУЗ-ын 2020 оны 7 дугаар тогтоолоор Мөрөн сумын 210 жил, хотгойдын хурд, даншиг наадамд 20.0 сая төгрөг ном, зургийн цомгийн үнэнд Төсвийн тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.10.”Төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээд хандив, тусламж өгөхийг хориглоно” заалтыг зөрчсөн байна.
- Хөвсгөл эрчим хүч ХХК-ийн худалдан авах ажиллагаа хариуцсан ажилтан албан тушаалын тодорхойлолт хангахгүй байна.

2.4.3.Төлөвлөгдөөгүй, хамааралгүй хөрөнгө оруулалтыг АИТХ-ын шийдвэрээр хэрэгжүүлсэн байна.

Зарим хуулийн этгээдийн төлөвлөөгүй, хэрэгцээ шаардлагагүй, хамааралгүй хөрөнгө оруулалтын ажлыг АИТХ-ын шийдвэрээр өөрийн хөрөнгөөр гүйцэтгүүлсэн байна. Тухайлбал:

- Хөвсгөл Эрчим хүч ХХК-ийн хамааралгүй үйл ажиллагаанд төлөвлөгдөөгүй “Хөвсгөл нуурын баруун эргийн 3.3 км, 15Кв-ын цахилгаан дамжуулах агаарын шугам барих ажил” хөрөнгө оруулалтын 111.9 сая төгрөгийн ажлыг компанийн 2019 оны бизнес төлөвлөгөөнд нэмэлт өөрчлөлт оруулан гүйцэтгэсэн байна. Төлөвлөгдөөгүй уг ажлын санхүүжилтийг Эрчим хүчний зохицуулах хорооны шийдвэрээр цахилгааны тарифт өөрчлөлт оруулж шийдвэрлэсэн байна.
- Хөвсгөл Эрчим хүч ХХК-ийн хамааралгүй үйл ажиллагаанд Аймагийн ИТХТ-ын 2019 оны 47 дугаар тогтоолоор Нэгдсэн эмнэлгийн цахилгаан хангамжийн хаалттай дэд өртөө, шугам сүлжээг засварлах, өргөтгөх ажилд 152.0 сая төгрөг зарцуулсан нь компанийн хөрөнгийн үр ашиггүй зарцуулсан, аймагийн орон нутгийн хөрөнгө оруулалтаар санхүүжүүлэхийг даалгасан хэдий ч шийдвэрлэгдээгүй байна.
- Хөвсгөл Эрчим хүч ХХК-ийн хамааралгүй үйл ажиллагаанд 25 м гэрлийн цамхаг барихад 250 сая төгрөг тус тус зарцуулсан байна.
- Тэсийн илч ХХК-д 2016 онд суурилуулсан уур үүсгэгч зуухны хөрөнгө оруулалт хийгдсэн байна. Уг зуух нь үйлдвэрлэлийн зориулалттай уур үүсгэгч бөгөөд иргэний барилгын халаалтад ашиглах боломжгүй байна. Мөн хөрөнгийг хүлээлгэж өгсөн баримт байхгүй, санхүү бүртгэлд тусгаагүй байна. Одоог хүртэл уур үүсгэгч зуухыг ашиглаагүй бөгөөд тоногдсон байдалтай байна. Энэ

хөрөнгийг ашиглах боломжийг судалж бүртгэлд тусгаж авах зөвлөмжийг ОНӨГ-т хүргүүлэв.

БҮЛЭГ 3.Төрийн болон орон нутгийн өмчит, өмчийн оролцоотой хуулийн этгээдэд тавих хяналт үр нөлөөгүй байна.

3.1 Аймгийн Засаг даргын зүгээс болон Орон нутгийн өмчийн газар үр нөлөөтэй хяналт хэрэгжүүлээгүй байна.

Орон нутгийн өмчит, өмчийн оролцоотой хуулийн этгээдийн үйл ажиллагаанд төрийн зүгээс Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газар, аймгийн МХГ, аймгийн Засаг даргын дэргэдэх СХАА нь аймгийн хэмжээнд төрийн хяналтын чиг үүргийг хэрэгжүүлэн ажиллаж байна.

Орон нутгийн өмчийн оролцоотой Могойн гол ХК-ийн үйл ажиллагаанд Санхүүгийн зохицуулах хороо нь Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн хүрээнд хувьцаат компани, хувьцаа эзэмшигчдийн эрх ашгийг хамгаалахад хуулийн шаардлагын дагуу байнга хяналт тавьж ажиллаж байна.

Эрчим хүчний зохицуулах хорооноос Хөвсгөл Эрчим хүч ХХК-ийн үйл ажиллагаа, үнэ тарифт хяналт тавьж удирдан чиглүүлж байна.

Аймгийн Орон нутгийн өмчийн газар жилийн эцсийн санхүүгийн тайланг нэгтгэн ТӨБЗГ-т мэдээлэхээс илүү хяналт шалгалтыг үр нөлөөтэй хийгээгүй байна.

Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д зааснаар Төрийн аудитын байгууллага жил бүрийн санхүүгийн тайланд аудит хийж дүгнэлт гарган ажилласан байна.

Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газар нь төрийн болон орон нутгийн өмчит, өмчийн оролцоотой хуулийн этгээдэд АИТХ-ын болон өөрийн санаачилгаар дараах гүйцэтгэлийн аудитыг хийсэн байна.

Хүснэгт №12

Тайлант он	Байгууллагын нэр	Акт		Албан шаардлага		Зөвлөмж		Үр өгөөж	
		тоо	дүн /сая.төг/	тоо	дүн /сая.төг/	тоо	дүн /сая.төг/	тоо	дүн /сая.төг/
2020 он	Хөвсгөл дулааны станц ТӨХК	1	0.3	1	731.9	17	2579.9	19	3312.1
2020 он	Могойн гол ХК					14	4439.9	14	4439.9
2021 он	Хөвсгөл ус суваг ХХК	1	2.2	1		20	750.8	22	753.0
	Нийт	2	2.5	2	731.9	51	7,770.6	55	8,505.0

Дээрх гүйцэтгэлийн аудитуудын хүрээнд аймгийн МХГ болон СХАА-ны тухайн байгууллагад ажилласан тайлан, илрүүлсэн зөрчилтэй танилцаж ажилласан байна.

Гүйцэтгэлийн аудитаар өгсөн зөвлөмжийн хэрэгжилтийг хангуулан ажилласан байна.

Аймгийн МХГ нь тухайн байгууллагын үйл ажиллагааны чиглэл тусгагдсан стандартын хэрэгжилтийг хянан ажиллаж байна.

3.2. Орон нутгийн өмчийн компаниудын ТУЗ-ын дэргэдэх дотоод аудит, эрсдэлийн удирдлага үр нөлөөгүй байна.

Орон нутгийн өмчит, өмчин оролцоотой компанийн ТУЗ-ын аудитын хороо нь компанийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэлийг олон улсын стандартад

нийцүүлэх, дотоод хяналтын болон эрсдэлийн удирдлагын үйл ажиллагаа, санхүүгийн тайлан, санхүү, эдийн засгийн бусад мэдээллийн үнэн бодит байдалд хяналт тавих үүргээ биелүүлээгүй байна.

Хараат бус гишүүд нь Компанийн тухай хуулийн 79 дугаар зүйлийн 79.4.1¹². 79.4.2¹³. заалтуудыг хэрэгжүүлж ажиллаагүйгээс орон нутгийн өмчит, өмчин оролцоотой компанийн засаглалын үйл ажиллагаа доголдож Төлөөлөн удирдах зөвлөл, гүйцэтгэх захирал, ажиллагсдын хоорондын уялдаа алдагдаж ТУЗ-ын дотоод аудитын хороо дотоод аудит, эрсдэлийн удирдлагыг хэрэгжүүлээгүй байна.

Могойн гол ХК-ийн захирлын 2021 оны 04 сарын 14-ний өдрийн А/09 тоот тушаалаар байгууллагын дотоод хяналтын нэгжийг шинэчлэн байгуулж, дотоод хяналтыг зохион байгуулах журам боловсруулан ажиллаж байгаа боловч эрсдэлийн сан байгуулаагүй, гүйцэтгэх удирдлага нь дотоод хяналтын талаар зохих мэдлэггүй, дотоод хяналт хийх туршлагатай боловсон хүчин байхгүйгээс дотоод хяналт, эрсдэлийн удирдлага хангалтгүй байна. Төрийн болон орон нутгийн өмчит, өмчийн оролцоотой компаниудын дотоод хяналтыг гүйцэтгэх удирдлагын тушаалаар байгуулагдсан орон тооны бус дотоод хяналтын нэгж, цөөн компанид орон тооны дотоод хяналтын ажилтан, аудитор гүйцэтгэж байна.

Дотоод хяналтын нэгж, ажилтан нь Засгийн газрын 2011 оны 11 дүгээр сарын 9-ний өдрийн тогтоолын дагуу дотоод хяналтыг 5 чиглэлээр хэрэгжүүлж байгаа боловч Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт, хөрөнгийн хадгалалт хамгаалалт, тооллогод хяналт тавьж байгаа боловч санхүү бүртгэлийн үйл ажиллагаанд тавих хяналт шалгалтыг орхигдуулсан байна.

Төрийн болон орон нутгийн өмчийн, өмчийн оролцоотой хуулийн этгээдийн мэдээллийг Аймгийн Орон нутгийн өмчийн газарт Excel хүснэгтээр нэгтгэн төрийн өмчийн бодлого зохицуулалтын газарт хүргүүлдгээс өөр мэдээлэл, нэгтгэл орон нутагт байхгүй байна.

Төрийн болон орон нутгийн өмчит, өмчийн оролцоотой хуулийн этгээдийн 2019 оноос 2021 оны шилэн дансны цахим хуудсанд мэдээлэл оруулсан байдлыг шалгахад дараах зөрчлүүд илэрлээ. Үүнд:

Хөвсгөл эрчим ХХК 2020 онд 5 сая-аас дээш үнийн дүн бүхий бараа, ажил, үйлчилгээний худалдан авалтын талаар мэдээлээгүй, нийт 516 мэдээлэл оруулахаас 230 мэдээлэл оруулаагүй, 16 мэдээллийг хугацаа хоцроосон.

Эмийн эргэлтийн сан 189 мэдээллийг оруулаагүй, 133 мэдээллийг хугацаа хоцорч мэдээлсэн.

Хөвсгөл АЗЗА ТӨХК 36 мэдээллийг хугацаа хоцорч мэдээлсэн.

Хөвсгөл ус суваг ХХК Шилэн дансны цахим хуудсанд 49 мэдээлэл байршуулах Шилэн дансны цахим хуудсанд зорилтот түвшин, гүйцэтгэл, санхүүгийн тайлан, 5 сая-аас дээш орлого, зарлагын мөнгөн гүйлгээ, аудитын дүгнэлттэй холбоотой цэсийг нээгээгүй. Тусламж, тэтгэмжээс бусад хөрөнгө зарцуулах шийдвэрийг мэдээлээгүй. Нийт 516 мэдээлэл оруулахаас 148 мэдээлэл оруулаагүй, 109 мэдээллийг хугацаа хоцроосон.

Мөрөн хот тохижилт үйлчилгээний төв ХХК шилэн дансны цахим хуудсанд зорилтот түвшин, гүйцэтгэл, санхүүгийн тайлан, 5 сая-аас дээш орлого, зарлагын мөнгөн

¹² Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн дагуу зохион байгуулах худалдан авалтын талаар санал боловсруулах;

¹³ гүйцэтгэх удирдлагатай байгуулсан гэрээний дагуу бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааг холбогдох хуулийн зарчимд нийцүүлэн үр ашигтай зохион байгуулж байгаа эсэхэд хяналт тавих

гүйлгээ, аудитын дүгнэлттэй холбоотой цэсийг нээгээгүй. Нийт 516 мэдээлэл оруулахаас 151 мэдээлэл оруулаагүй, 75 мэдээллийг хугацаа хоцроосон.

Шинэ Мөрөн худалдааны төв ХХК Төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулсан шийдвэрийг байршуулаагүй, нийт 516 мэдээлэл оруулахаас 32 мэдээлэл оруулаагүй, 278 мэдээллийг хугацаа хоцроосон.

Могой гол ХК нийт 516 мэдээлэл оруулахаас 1 мэдээлэл оруулаагүй, 16 мэдээллийг хугацаа хоцроосон.

Тэсийн илч ХХК 2019 онд Төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулсан шийдвэрийг байршуулаагүй нийт 516 мэдээлэл оруулахаас 3 мэдээлэл оруулаагүй, 52 мэдээллийг хугацаа хоцроосон.

Галт дулаан ХХК 516 мэдээлэл оруулахаас 49 мэдээллийг хугацаа хоцроосон.

Түнэл илч ХХК Шилэн дансны цахим хуудсанд зорилтот түвшин, гүйцэтгэл, санхүүгийн тайлан, 5 сая-аас дээш орлого, зарлагын мөнгөн гүйлгээ, аудитын дүгнэлттэй холбоотой цэсийг нээгээгүй. Хөрөнгө зарцуулах шийдвэрийг мэдээлээгүй, нийт 516 мэдээлэл оруулахаас 99 мэдээлэл оруулаагүй, 100 мэдээллийг хугацаа хоцроосон. /Хавсралт 1-ээс харна уу/

ДҮГНЭЛТ:

Аудитын дүнд үндэслэн дараах дүгнэлтийг гаргаж байна.

1. Орон нутгийн өмчит, өмчийн оролцоотой хуулийн этгээдүүд эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшнийг төлөөлөн удирдах зөвлөлөөр хэлэлцүүлж, хянуулахгүй орон нутгийн өмчийн газарт хүргүүлж АИТХ-аар баталгаажуулсан байна.
2. Орон нутгийн өмчит, өмчийн оролцоотой хуулийн этгээдүүдийн төлөөлөн удирдах зөвлөл, төрийн төлөөллийг сонгон шалгаруулалтаар томилоогүй, орон нутгийн өмчит компаний төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийн тоо их ес байх нь удирдлагын зардлыг нэмэгдүүлж үр ашигт нөлөөлж байна.
3. Орон нутгийн өмчит, өмчийн оролцоотой хуулийн этгээдүүдийн компанийн засаглалын талаар төрөөс баримталж байгаа бодлогын хэрэгжилт, түүнд тавих хяналт хангалтгүй, ил тод мэдээлэгдэхгүй байна.
4. Орон нутгийн өмчит, өмчийн оролцоотой хуулийн этгээдүүдийн эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшнийг төлөвлөхдөө үйлдвэрлэл ба удирдлагын зардлыг салгаагүй зардлыг нийт дүнгээр төлөвлөсөн, мөнгөн орлого зарлагын урсгалыг тооцоогүй төлөвлөснөөс төлөвлөсөн ажил, хөрөнгө оруулалтын зорилтоо бүрэн хэрэгжүүлэхэд хүндрэл гарсан байна.
5. Могойн гол ХХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн төрийг төлөөлөх гишүүд ИТХ-аас гаргасан заавар, удирдамжийг дагаагүйгээс Хөвсгөл аймгийн ИТХ нь өмчийн 51 хувийн давуу байдлаа ашиглаж чадахгүй компанийн засаглалын хэвийн үйл ажиллагааг алдагдуулж байна.
6. Могойн гол ХК нь дэлхийн зах зээлд нүүрсний үнэ түүхэн дээд амжилт тогтоосонтой холбогдуулж коксжих нүүрсний үнийг зах зээлийн нөхцөл байдалд уялдуулан үндэслэлтэй тогтоож чадаагүйгээс ашгаас нэмэгдүүлэх боломжийг алдаж, Коксжих нүүрсийг экспортод гаргах, нүүрсийг боловсруулан эцсийн бүтээгдэхүүн үйлдвэрлэх зэрэг нэмүү өртгийг шингээх боломжийг ашиглаж чадахгүй байна.
7. Сумын төвийн дулаан түгээх үйл ажиллагаа явуулдаг нэр бүхий 7 компани нь тухайн сумын төрийн болон төвийн шугамд холбогдсон бусад газруудаас халаалтын төлбөрийн орлогыг тогтоосон тарифын дагуу тогтмол төвлөрүүлэн ажиллаж байгаа хэдий ч бусад орлого нэмэгдүүлэх, ашигтай ажиллах үйл ажиллагааг судлан хэрэгжүүлэхгүй байна.

ЗӨВЛӨМЖ:

Аудитын дүн, дүгнэлт нотлох зүйлст үндэслэн дараах зөвлөмжийг өгч байна.Үүнд:

Аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын дарга Г.Мөнгөнхуягт

1. Орон нутгийн өмчит компанид төлөөлөн удирдах зөвлөл байх эсэх, гишүүдийн тоог цөөлөх асуудлыг Компанийн тухай хуулийн 75 дугаар зүйлийн 75.2. "Хувьцаат компани нь төлөөлөн удирдах зөвлөлтэй байх бөгөөд хязгаарлагдмал хариуцлагатай компанийн дүрэмд өөрөөр заагаагүй бол төлөөлөн удирдах зөвлөлгүй байж болно" заалтыг эргэн харж шийдвэрлэх.
2. Хөвсгөл аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын хуралдааны 2019 оны 4 дүгээр сарын 3-ны өдрийн тогтоолд заасан зөрчил арилсан эсэхийг хэлэлцэж, экспортын зориулалттай нүүрс тээвэрлэлтийг үргэлжлүүлэх эсэх талаар тодорхой шийдвэр гарган, Могойн гол ХК-ийг хууль тогтоомжийн дагуу ажиллах боломжийг бүрдүүлэх
3. Хөвсгөл аймгийн ИТХ-аас Могойн гол ХК-тай холбоотой гаргасан шийдвэр, удирдамж, зааврыг зөрчсөн Төлөөлөн удирдах зөвлөлийн төрийг төлөөлөх гишүүдэд хариуцлага тооцож, ТУЗ-д дахин нэр дэвшүүлэхгүй байх
4. Могойн гол ХК-ийн эдийн засгийн үзүүлэлт зорилтот түвшнийг Хувьцаа эзэмшигчдийн хурлаар батлуулж байх

Аймгийн Засаг дарга Ш.Идэрбаясгаланд:

1. Орон нутгийн өмчит, өмчийн оролцоотой хуулийн этгээдүүдийн төлөөлөн удирдах зөвлөл, төрийн төлөөллийг сонгон шалгаруулж, шаардлага хангасан төрийн төлөөллийг АИТХ-д нэр дэвшүүлэн шийдвэрлүүлж байх.

Орон нутгийн өмчийн газрын даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч Б.Должинсорогдогт:

1. Орон нутгийн өмчит, өмчийн оролцоотой хуулийн этгээдүүдийн төлөөлөн удирдах зөвлөлөөр хэлэлцүүлсэн эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшнийг хянаж АИТХ, болон хувьцаа эзэмшигчийн хурлаар баталгаажуулж байх.
2. Орон нутгийн өмчит, өмчийн оролцоотой хуулийн этгээдүүдийн компанийн засаглалын талаар төрөөс баримталж байгаа бодлогын хэрэгжилтийг ханган ажиллах.

Төрийн болон орон нутгийн өмчит, өмчийн оролцоотой хуулийн этгээдүүдийн хувьцаа эзэмшигчдийн хуралд:

1. Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийн цалин, урамшууллыг гишүүдийн хийсэн ажил, байгууллагын үр дүнг харгалзан тогтоож байх

Төрийн болон орон нутгийн өмчит, өмчийн оролцоотой компаниудын гүйцэтгэх удирдлагуудад:

1. Эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшнийг боловсруулахдаа үйлдвэрлэл, удирдлагын зардлыг салгаж, мөнгөн орох, гарах урсгалыг тооцож хэрэгжих боломжтой, бодит судалгаа тооцоонд үндэслэн төлөвлөж, ТУЗ-аар хянуулж хэлэлцүүлсний дараа хувьцаа эзэмшигчдийн хурлаар баталгаажуулж байх

2. Шилэн дансны цахим хуудсан байвал зохих цэс, үзүүлэлтийг бүрэн оруулж, шилэн дансны тухай хуулийг бүрэн хэрэгжүүлж ажиллах
3. Үндсэн үйл ажиллагаанаас орох орлогын батлагдсан төлөвлөгөөг биелүүлж ажиллах, бусад эх үүсвэрээс олж болох орлогын эх үүсвэрийг нэмэгдүүлж ажиллах

Орон нутгийн өмчийн компаниудын ТУЗ-д

1. Гүйцэтгэх захиралтай байгуулсан гэрээний хэрэгжилтэд хяналт тавьж үр дүнг бодитой үнэлэн урамшуулал олгох асуудлыг шийдвэрлэж байх
2. Орон нутгийн өмчит, өмчин оролцоотой компанийн ТУЗ-ын аудитын хороо нь компанийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэлийг олон улсын стандартад нийцүүлэх, дотоод хяналтын болон эрсдэлийн удирдлагын үйл ажиллагаа, санхүүгийн тайлан, санхүү, эдийн засгийн бусад мэдээллийн үнэн бодит байдалд хяналт тавих үүргээ биелүүлээгүй байна

Могойн гол ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлд:

1. Коксжих нүүрсний үнийг нэмэгдүүлэх асуудлыг хэлэлцэж, 2022 онд одоогийн үнийг нүүрсний чанараас хамааруулан 10-аас доошгүй хувиар нэмэгдүүлж, цаашид зах зээлийн үнийг харгалзан уян хатан байдлаар тогтоож байх
2. Компанид үр ашиггүй зардал болох ТУЗ-ын гишүүдийн гадаад томилолтын зардлыг бизнес төлөвлөгөөнд тусгаж батлахгүй байх.
3. Төрийн болон орон нутгийн өмчит, өмчийн оролцоотой хуулийн этгээдтэй холбоотой хууль тогтоомж болон Монгол Улсын Засгийн газраас баримталж буй бодлого шийдвэрийг бүрэн хэрэгжүүлж ажиллах
4. Төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх нэр дэвшүүлэх хороо, аудитын хорооны гишүүд хууль тогтоомжид заасан эрх үүргээ бүрэн хэрэгжүүлэн ажиллах
5. Компанийн үйлдвэрлэлд ашиглаж байгаа машин, тоног төхөөрөмж хуучирч ашиглалтын зардлыг нэмэгдүүлж байгаад дүгнэлт хийж машин, тоног төхөөрөмжийн шинэчлэлийг хийж компанийн хэвийн үйл ажиллагааг дэмжин ажиллах

Могойн гол ХК-ийн гүйцэтгэх захирлын үүргийг түр орлон гүйцэтгэгч Б.Батхүүд:

1. Тухайн онд төлбөл зохих улс, орон нутгийн төсөвт төвлөрүүлэх татвар, төлбөр, хураамжийг тайлант хугацаанд нь төвлөрүүлж байх
2. Бизнес төлөвлөгөөнд тусаагүй ажил гүйлгээг ТУЗ-д танилцуулж, шийдвэр гаргуулж байх
3. Дотоод хяналтын үйл ажиллагааны талаар зохих мэдлэг туршлагатай ажилтныг дотоод хяналтын нэгжид ажиллуулж, эрсдэлийн сан үүсгэж, эрсдэлд үзүүлэх удирдлагын хариу үйлдлийг боловсруулан эрсдэлд суурилсан дотоод хяналтын системийг бүрдүүлж ажиллах
4. Компани коксжих нүүрсийг экспортод гаргах, эцсийн бүтээгдэхүүн үйлдвэрлэх боломжийг судалж хэрэгжүүлэх арга хэмжээг авч ажиллах

Хөвсгөл эрчим хүч ХХК-ийн захирал З.Бадралд:

1. Компанийн үйл ажиллагааны чиглэлд хамаарахгүй үйл ажиллагааг АИТХ-ийн шийдвэрээр гүйцэтгэхгүй байх
2. Компанийн эдийн засгийн зорилтот түвшинд тусгагдаагүй үр ашиггүй зардал гаргахгүй байх
3. Худалдан авах ажиллагаанд ажлын даалгавар, техникийн нөхцөлийн төлөвлөлт, гүйцэтгэлд тавих хяналтыг сайжруулж, худалдан авах ажиллагаанд албан тушаалын тодорхойлолтод нийцсэн ажилтан ажиллуулж байх
4. Дотоод хяналтын ажлын төлөвлөгөөний хэрэгжилтийг бүрэн хангаж ажиллах.

Цэцэрлэг сумын ИТХ-ын дарга Б.Бүд-д:

1. Тэсийн илч ХХК-ийн ТУЗ-ийн даргыг томилж, ТУЗ-ийн үйл ажиллагааг сайжруулах ажлыг зохион байгуулах.

Цагаан-Уул сумын ИТХ-ын дарга Алтанбаатар-т

1. Галт дулаан ХХК-ийн дүрэмд шаардлагатай өөрчлөлт оруулж, шаардлага хангасан ТАХ-ийг төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүнд томилон үр нөлөөтэй ажиллуулах.

Галт дулаан ХХК-ийн захирал Д.Мөнх-Очирт

1. Галт дулаан ХХК-ийн үйлдвэрлэлийн өртөг, борлуулалтын үнийн тооцоо судалгаа хийж үр ашгийг дээшлүүлэн ажиллах.

Шинэ Мөрөн Худалдааны Төв ХХК-ийн гүйцэтгэх захирал Ц.Нацагдорж-д:

1. Шинэ Мөрөн Худалдааны төвийн гадна талбайн түрээслэгч иргэдтэй Төрийн өмчийг түрээслэх тухай журам болон бусад хууль эрх зүйн хүрээнд тулгарч болох эрсдэлээс сэргийлсэн, төр болон иргэний эрх ашгийг хамгаалсан гэрээг байгуулж ажиллах

ЗӨРЧЛИЙН ЖАГСААЛТ:

/Сая төгрөг/

№	Илэрсэн зөрчлийн		Акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Утга	дүн	тоо	дүн	тоо	дүн	тоо	дүн
1	Үүрийн долгио ХК нь МУИХ-ын 1999 оны 29 дүгээр тогтоолоор төрийн өмчөөс аймагт шилжин ирсэн /төрийн өмчийн эзлэх хувь 32.3, нийт хөрөнгийн хэмжээ 12.4 сая төгрөг бөгөөд төрийн өмчийн эзлэх хувь 2.8 сая төгрөг/ хөрөнгө бөгөөд хаана хэн харьяалж байгаа нь тодорхойгүй, бүртгэл мэдээлэлгүй компани байна.	12.4					1	12.4
2	Галт дулаан ХХК-ийн ТУЗ-ын 5 гишүүн засаглалын сургалтын гэрчилгээгүй байна.						1	
3	Хөвсгөл Эрчим хүч ХХК-ийн ТУЗ-ийн бүрэлдэхүүнд Т.Амартүвшин /2021 он, 2022 он /, С.Долгоржав /2019 он/, Х.Рагчаа /2022 он/ нарын төрийн үйлчилгээний ажилтнуудыг хараат гишүүнээр томилсон байна.						1	
5	Орон нутгийн өмчийн 51 хувийн оролцоотой Могойн гол ХК-ийн эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшнийг Хөвсгөл аймгийн ИТХ-аар баталж байгаа нь Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлд заасан хувьцаа эзэмшигчдийн бүрэн эрхтэй нийцэхгүй байна.						1	
6	Могойн гол ХК-ийн төрийг төлөөлөх ТУЗ-ын зарим гишүүд 2021 оны ноогдол ашиг олголтыг хойшлуулах, шинээр дэд захирлын орон тоог бий болгох, ТУЗ-ын зардлыг нэмэгдүүлэх, коксжих нүүрсний үнийг зах зээлийн таатай нөхцөлтэй уялдуулан бодитой тогтоох асуудалд 51 хувийн хувьцаа эзэмшигч болох ИХТ-ын санал, удирдамжийг зөрчсөн, компанийн эрх ашигтай нийцэхгүй саналыг дэмжиж ажилласан байна.						1	
7	Могойн гол ХК экспортын зориулалттай коксжих нүүрсийг борлуулж байгаа нь Хөвсгөл аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын хуралдааны 2019 оны 4 дүгээр сарын 3-ны өдрийн тээвэрлэлт болон технологийн горимтой холбогдох зөрчил арилгах хүртэл Хөвсгөл аймгаас экспортын зориулалтаар нүүрс борлуулахыг хориглосон "Могойн гол" ХК-ийн талаар авах арга хэмжээний тухай"						1	

	2 дугаар тогтоолтой нийцэхгүй байна. Уг тогтоолын технологийн горимтой холбогдох зөрчил арилсан ба тогтоол одоог хүртэл хүчинтэй байна. Могойн гол ХК экспортын зориулалттай нүүрс борлуулж хэвийн үйл ажиллагааг ханган ажиллах боломжтой байна.							
8	Хөвсгөл аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2 дугаар сарын 21-ний өдрийн 01/76 тогтоол, Могойн гол ХК-ийн ТУЗ-ийн 2022 оны 02 дугаар сарын 22-ны өдрийн 8 дугаар тогтоолын дагуу Хөвсгөл аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын нэмэлт санхүүжилтийн дансанд 20.0 сая төгрөг шилжүүлэн үр ашиггүй зардал гаргасан байна.	20.0	1	20				
9	Бизнес төлөвлөгөөнд ТУЗ-ийн гадаадад томилолтоор явах зардал гэж 2021 онд 50.0 сая төгрөгийг компанид үр ашиггүй зардал баталсан байна.	50.0					1	50
10	ТУЗ-ын 2021 оны 5 дугаар сарын 21 -ний өдрийн 02 тоот тогтоолоор 2021 оны зардлын төсвийн батлахдаа ТУЗ-ийн гишүүний урамшууллыг 0.4 сая төгрөг байсныг 0.8 сая төгрөг болгож нэмэгдүүлсэн байна	43.2					1	43.2
11	Өнөөгийн байдлаар Хятад улсын зах зээлд 1 тонн коксжих нүүрсний үнэ дунджаар 2,000 юаньд хүрээд байгаа ба энэ нь өмнөх оноос бараг 3 дахин өссөн үзүүлэлт ба 2022 онд үнэ тогтвортой хадгалагдах прогнозтой байна. Могойн гол ХК-ийн бизнес төлөвлөгөөнд эдийн засгийн зорилтот түвшнийг батлахдаа коксжих 1 тонн нүүрсний үнийг НӨАТ-гүйгээр 60,000 төгрөгөөр тогтоосон нь зах зээлийн нөхцөл байдалд тулгуурлан бодитой тогтоож чадаагүй байна.	300.0					1	300.0
12	Компанийн засаглалын үйл ажиллагаа доголдож Төлөөлөн удирдах зөвлөл, гүйцэтгэх захирал, ажиллагсдын хоорондын уялдаа алдагдсан байна. Хараат бус гишүүд нь Компанийн тухай хуулийн 79.4.1.Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн дагуу зохион байгуулах худалдан авалтын талаар санал боловсруулах; 79.4.2.гүйцэтгэх удирдлагатай байгуулсан гэрээний дагуу бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааг холбогдох хуулийн зарчимд нийцүүлэн үр ашигтай						1	

	зохион байгуулж байгаа эсэхэд хяналт тавих заалтуудыг хэрэгжүүлж ажиллаагүй байна.							
13	Могойн гол ХК-ийн улс, орон нутгийн төсөвт 2021 онд төлөх татвар хураамж нийт 405.9 сая төгрөгийг Хөвсгөл аймгийн Татварын хэлтсийн хүсэлтээр хойшлуулж 2022 онд төлсөн байна.	405.9					1	405.9
14	Могойн гол ХК, Эмч нарыг дэмжигч төрийн бус байгууллагатай Могойн гол ХК-ийн ажилчдыг нарийн мэргэжлийн эмчийн өвчнийг эрт илрүүлэх урьдчилан сэргийлэх үзлэг оношилгоонд хамруулан эмчлэн эрүүлжүүлэх зорилгоор түншлэлийн гэрээ байгуулж, ТУЗ-д танилцуулалгүй 2022 оны 5 дугаар сарын 3-ны өдөр 30.0 сая төгрөг шилжүүлсэн байна.	30.0			1	30		
15	Могойн гол ХК-ийн захирлын 2021 оны 04 сарын 14-ний өдрийн А/09 тоот тушаалаар байгууллагын дотоод хяналтын нэгжийг шинэчлэн байгуулж, дотоод хяналтыг зохион байгуулах журам боловсруулан ажиллаж байгаа боловч эрсдэлийн сан байгуулаагүй, дотоод хяналт хийх туршлагатай боловсон хүчин байхгүйгээс дотоод хяналт, эрсдэлийн удирдлага хангалтгүй байна.						1	
16	Цагаан-Уул сумын ИТХ-ийн зөвшөөрснөөр Галт дулаан ХХК нь Идэр нумт ХХК-тай дулааны шугам шинэчлэх төслийн ажилд төр хувийн хэвшлийн түншлэлийн гэрээгээр 2019 онд 1,980.0 сая төгрөгийн их хэмжээний хэлцэл хийж, хэлцлийг сумын засаг дарга Т.Түмэнбаяр баталгаажуулсан нь Компанийн тухай хуулийн 83 дугаар зүйлийн 83.8[2] дах хэсгийг зөрчсөн байна.							
17	Цагаан уул сумын дулааны шугам шинэчлэх төслийн ажлыг хүлээж авах улсын комисс үр дүнгүй ажилласнаас дээрх маргаан үүссэн, төслийн ажилд чанарын хяналт хийгээгүй байна.	1,980.0			1	1,980.00		
18	Хөвсгөл эрчим хүч ХХК-ийн гүйцэтгэх захирал Г.Очирхуягт Гүйцэтгэх захиралтай байгуулсан гэрээний 4.3.1-д заалтыг зөрчиж Эрчим хүч ХХК нь 2019 оны зорилтот түвшний үзүүлэлт бүрэн биелээгүй авлага 3.6 дахин өссөн,	7.8					1	7.8

	өглөг 2.1 дахин өссөн байх гүйцэтгэх захирал г.Очирхуягт 7.8 сая төгрөгийн урамшуулал олгосон байна.							
19	Хөвсгөл эрчим хүч ХХК-ийн ТУЗ-ийн 2019 оны 10 дугаар сарын 12 дугаар тогтоолоор Турк улсад ТУЗ-ийн гишүүдийн туршлага судлахад 44.0 сая төгрөг зарцуулсан нь компанийн удирдлагын зардлыг нэмэгдүүлсэн, шаардлагагүй зардал гарч, томилолтын үр дүн, үр нөлөө гараагүй байна.	44.0					1	44
20	ТУЗ-ийн 2019 оны 10 дугаар сарын 18 дугаар тогтоолоор компанийн ерөнхий нягтлан А.Бүдсүрэнд гадаад томилолтод 10.0 сая төгрөг зарцуулсны үр нөлөө, үр дүнг тооцоогүй байна	10.0					1	10
21	Хөвсгөл эрчим хүч ХХК Аймгийн ИТХТ-ын 2019 оны 47 дугаар тогтоолоор замын хөдөлгөөний хяналтын постын цахилгааны эх үүсвэрийг шийдвэрлэхэд 10.0 сая төгрөг, аймгийн эх хүүхэд нөхөн үржихүйн эрүүл мэнд хөтөлбөрт 4.0 сая төгрөг, сүрьеэгийн илрүүлэг үзлэгт 2.0 сая төгрөг, бэлгийн замаар дамжих халдварт өвчин илрүүлэхэд 5.0 сая төгрөг нийт 11.0 сая төгрөгийг аймгийн ЭМГ-т шилжүүлж үр ашиггүй зардал гаргасан.	32.0					1	32
22	Хөвсгөл эрчим хүч ХХК Гүйцэтгэх захирлын 2021 оны А/92 тушаалаар Компанийн 55 жилийн ойн болон эрчим хүчний ажилтны өдрийг тэмдэглэхэд 20.0 сая төгрөг зарцуулсан байна	20.0					1	20
23	Хөвсгөл эрчим хүч ХХК ТУЗ-ийн 2019 оны 09 тогтоолоор Тариалан ЕБС 5.0 сая, Алаг эрдэнэ ЕБС - 5.0 сая, Нийтийн номын сангийн газарт 4.5 сая ойн хандив тусламжид хөрөнгө зарцуулсан байна.	14.5					1	14.5
24	Хөвсгөл эрчим хүч ХХК ТУЗ-ын 2020 оны 7 дугаар тогтоолоор Мөрөн сумын 210 жил, хотгойдын хурд, даншиг наадамд 20.0 сая төгрөг ном, зургийн цомгийн үнэнд, 25 м гэрлийн цамхаг барихад 250 сая төгрөг тус тус зарцуулсан нь байна.	270.0					1	270
25	Тэсийн илч ХХК-д 2016 онд суурилуулсан уур үүсгэгч зуухны хөрөнгө оруулалт хийгдсэн байна. Уг зуух нь үйлдвэрлэлийн зориулалттай уур үүсгэгч бөгөөд иргэний барилгын халаалтад ашиглах боломжгүй байна.						1	

26	Эрчим хүч ХХК-ийн хамааралгүй үйл ажиллагаанд төлөвлөгдөөгүй “Хөвсгөл нуурын баруун эргийн 3.3 км, 15Кв-ын цахилгаан дамжуулах агаарын шугам барих ажил” хөрөнгө оруулалтын ажлыг компанийн 2019 оны бизнес төлөвлөгөөнд нэмэлт өөрчлөлт оруулан гүйцэтгэсэн байна.	170.0					1	170
27	Орон нутгийн өмчит, өмчин оролцоотой компанийн ТУЗ-ын аудитын хороо нь компанийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэлийг олон улсын стандартад нийцүүлэх, дотоод хяналтын болон эрсдэлийн удирдлагын үйл ажиллагаа, санхүүгийн тайлан, санхүү, эдийн засгийн бусад мэдээллийн үнэн бодит байдалд хяналт тавих үүргээ биелүүлээгүй байна.						1	
28	Шинэ Мөрөн Худалдааны Төв ХХК нь тус байгууллагын эзэмшилд байдаг газарт худалдаа эрхлэгчдэд өөрсдийн хөрөнгөөр барилга байгууламж барьж худалдаа эрхлэх зөвшөөрөл олгосон байна. Ингэхдээ тухайн худалдаа эрхлэгчидтэй газрын эзэмших эрх, бусад тулгарч болох асуудлуудыг хэрхэн зохицуулах талаар ямар нэгэн гэрээ хэлцлийг байгуулаагүй байна. Энэ нь цаашид газар эзэмших эрх болон хөрөнгийн маргаан үүсэх эрсдэлийг үүсгэж байна.						1	
	ДҮН	3,409.8	1	20.0	2	2,010.0	22	1,379.8



ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР АКТ

2022 оны 06 сарын 30 өдөр

№ 13/А.22.70436/ХӨА-2022/
22-21-ШТА-ГА

Мөрөн сум

Төлбөр барагдуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд хийсэн “Төрийн болон орон нутгийн өмчит, өмчийн оролцоотой хуулийн этгээдийн үйл ажиллагааны үр ашиг” гүйцэтгэлийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Хөвсгөл аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын даргын 2 дугаар сарын 21-ний өдрийн 01/76 албан тоотоор ирүүлсэн хүсэлт, Могойн гол ХК-ийн ТУЗ-ийн 2022 оны 02 дугаар сарын 22-ны өдрийн 8 дугаар тогтоолын дагуу Могойн гол ХК-ийн гүйцэтгэх захирлын үүргийг түр орлон гүйцэтгэгч Б.Батхүү Хөвсгөл аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын нэмэлт санхүүжилтийн дансанд 20,000,000 /Хорин сая/ төгрөгийг Монгол Улсын Үндсэн хууль батлагдсаны 30 жилийн ойн арга хэмжээнд зарцуулахаар хандивласан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 25.10 “Төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээд хандив, тусламж өгөхийг хориглоно” заалттай нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2-т “Шалгагдагч этгээд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаа болон төсвийн орлого бүрдүүлэх, зарцуулах, нийтийн өмч, хөрөнгө олж бэлтгэх, ашиглах, зарцуулах, хадгалах, хамгаалахтай холбоотой хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн бол төлбөрийн акт тогтооно”, Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох” журмын 4.2.3-д “Төлбөрийн акт тогтооход дараах нийтлэг үндэслэлийг харгалзана. Үүнд:... 4.2.3.1 төрийн өмч хөрөнгийг үндэслэлгүйгээр бусдад хандивласан, үнэ төлбөргүй шилжүүлсэн” гэж заасныг үндэслэн **ТОГТООХ нь:**

1. Могойн гол ХК-иас Монгол Улсын Үндсэн хууль батлагдсаны 30 жилийн ойн арга хэмжээнд зарцуулахаар хандиваар хүлээн авсан 20,000,000 /Хорин сая/ төгрөгийг Төрийн сан банкин дахь Хөвсгөл бусад нэр заагдаагүй орлогын 100170000955 тоот дансанд төвлөрүүлэх;
2. Актын биелэлтийг 2022 оны 10 дугаар сарын 20-ны дотор Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэхийг иргэдийн Төлөөлөгчдийн хурлын нарийн бичгийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Р.Машбат, нягтлан бодогч Т.Амартүвшин нарт даалгав.

ТӨЛБӨРИЙН АКТ ТОГТООСОН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТОР

А.ЭРДЭНЭБААТАР
С.ГАНСҮХ

¹ Монгол Улс, Хөвсгөл аймаг, Мөрөн сум, 8-р баг, Хөвсгөл аймгийн ЗДТГ-ын байр 3 давхар 302 тоот



ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2022 оны 06 сарын 30 өдөр

№ 67/А2270436/ХӨА-2022/
22-21-ШТА-ГА.

Мөрөн сум

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд хийсэн “Төрийн болон орон нутгийн өмчит, өмчийн оролцоотой хуулийн этгээдийн үйл ажиллагааны үр ашиг” гүйцэтгэлийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Могойн гол ХК нь бизнес төлөвлөгөөнд тусгаагүй, ТУЗ-д танилцуулж зөвшөөрөл авалгүй нийт ажилчдад эрүүл мэндийн боловсрол олгох, эрүүл мэндийн тусламж үйлчилгээг үзүүлэх зорилгоор 2 жилийн хугацаатай түншлэлийн гэрээг “Эмч нарыг дэмжигч” төрийн бус байгууллагатай байгуулж, 2022 оны 5 дугаар сарын 3-ны өдөр 30,000,000/гучин сая/ төгрөг шилжүүлсэн байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1 “Захирал дараах эрх, үүрэгтэй:... 3/үйлдвэрийн газрын үйлдвэрлэл, санхүүгийн төлөвлөгөө боловсруулж, зохих байгууллагаар батлуулан биелэлтийг хангах...”, Компанийн тухай хуулийн 83 дугаар зүйлийн 83.8 “Гүйцэтгэх удирдлага нь төлөөлөн удирдах зөвлөлөөс олгосон эрх хэмжээний хүрээнд хэлцэл хийх, гэрээ байгуулах, компанийг төлөөлөх зэргээр компанийн нэрийн өмнөөс итгэмжлэлгүйгээр үйл ажиллагаа явуулна” заалтуудтай нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 “Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө” Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох” журмын 4.2.3-д “Төлбөрийн акт тогтооход дараах нийтлэг үндэслэлийг харгалзана. Үүнд: 4.2.1.11. Хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал” гэж заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Бизнес төлөвлөгөөнд тусгаагүй, ТУЗ-ын зөвшөөрөлгүй арга хэмжээнд хөрөнгө зарцуулсан зөрчлийг таслан зогсоож, биелэлтийг 2022 оны 12 дугаар сарын 20-ны дотор Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид гарсан алдаа зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Могойн гол ХК-ийн гүйцэтгэх захирлын үүргийг түр орлон гүйцэтгэгч Б.Батхүү, нягтлан бодогч Л.Шинэцэцэг нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

АУДИТОР

А.ЭРДЭНЭБААТАР

С.ГАНСҮХ



ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2022 оны 06 сарын 30 өдөр

№ 68/A.2260435/ХӨА-2022
22-21-ШТА-ГА.

Мөрөн сум

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд хийсэн “Төрийн болон орон нутгийн өмчит, өмчийн оролцоотой хуулийн этгээдийн үйл ажиллагааны үр ашиг” гүйцэтгэлийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Цагаан-Уул сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын зөвшөөрснөөр Галт дулаан ХХК нь 1,889,889,988 /Нэг тэрбум найман зуун наян есөн мянган есөн зуун наян найм/ төгрөгийн “Цагаан-Уул сумын төвийн дулааны шугам сүлжээ, зуухны шинэчлэлтийн ажлыг хэрэгжүүлэх төр, хувийн хэвшлийн хамтын ажиллагааны гэрээ”-г Идэр нумт ХХК-тай байгуулан ажлыг гүйцэтгүүлсэн байна.

Дулааны шугам сүлжээ, зуухны шинэчлэлтийн ажилд техникийн болон зохиогчийн хяналт хийгдээгүй, ашиглалтад оруулах улсын комисс үр дүн муутай ажилласан, улсын комисс зөрчил арилсан эсэхэд дахин хяналт хийгээгүй, зөрчил арилаагүй байна.

Энэ нь Барилгын тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.1.1-д “Барилга байгууламж дараах шаардлагыг хангасан байна: зураг төслийн дагуу баригдсан байх”, Засгийн газрын 2018 оны 317 дугаар тогтоолоор батлагдсан “Барилга байгууламжийг ашиглалтад оруулах дүрэм”-ийн 4.7-д “Захиалагч, гүйцэтгэгч талууд илэрсэн зөрчил дутагдлыг 14 хоногт багтаан арилгаж, комиссын хуралдаанаас даалгасан үүрэг даалгаврын биелэлтийг хангаж, шаардлагатай баримт бичгийг бүрдүүлнэ.” гэж заасантай нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 “Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө” Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам”-ын 4.2.1.11-д “Албан шаардлага өгөхөд дараах нийтлэг үндэслэлийг харгалзана. Үүнд: ...4.2.1.11. Хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал” гэж заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Барилгын тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4-д “Энэ хуулийн 14.3-т заасан хугацаа дуусгавар болсон тохиолдолд гүйцэтгэгч, зураг төсөл зохиогч, захиалагч болон ашиглагч тухайн барилга байгууламжид хамтарсан үзлэг хийж, зөрчлийг арилгах талаар тэмдэглэл үйлдэнэ.”, 14.5-д “Энэ хуулийн 14.4-т заасны дагуу зөрчлийг арилгаснаар энэ хуулийн 14.3-т заасан хугацаа дуусгавар болсонд тооцно.” дагуу заасны дагуу улсын комисстой хамтарсан үзлэгийг зохион байгуулж, илэрсэн зөрчлийг арилгах талаар арга хэмжээ авч, биелэлтийг 2022 оны 12 дугаар сарын 20-ны дотор Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Хөвсгөл аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөгжлийн бодлого төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга Б.Оюунтуяа, Цагаан-Уул сумын Засаг дарга С.Гончигням, Галт дулаан ХХК-ийн захирал Д.Мөнх-очир нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

АХЛАХ АУДИТОР

Г.ЭРДЭНЭБААТАР

Г.ЭРДЭНЭЧИМЭГ

¹ Монгол Улс, Хөвсгөл аймаг, Мөрөн сум, 8-р баг, Хөвсгөл аймгийн ЗДТГ-ын байр 3 давхар 302 тоот

Шилэн дансны сайтад мэдээлэл оруулсан байдал

ХАВСРАЛТ 1 №13

Компанийн нэр	2019 он				2020 он				2021 он			
	Мэдээлбэл зохих	Хугацаанд нь мэдээлсэн	Хугацаа хоцорсон	Мэдээлээгүй	Мэдээлбэл зохих	Хугацаанд нь мэдээлсэн	Хугацаа хоцорсон	Мэдээлээгүй	Мэдээлбэл зохих	Хугацаанд нь мэдээлсэн	Хугацаа хоцорсон	Мэдээлээгүй
Хөвсгөл Эрчим хүч ХХК	170	51	11	108	173	76	2	95	173	143	3	27
Эмийн эргэлтийн сан ХК	170	86	80	4	173	54	38	81	173	54	15	104
Хөвсгөл АЗЗА ТӨХК	170	162	8		173	167	6		173	151	22	
Хөвсгөл ус суваг ХХК	170	102	18	50	173	112	12	49	173	45	79	49
Мөрөн хот тохижилт үйлчилгээний төв ХХК	170	69	51	50	173	98	24	51	173	123		50
Шинэ Мөрөн худалдааны төв ХХК	170	116	52	2	173	50	114	9	173	40	112	21
Могой гол ХК	170	164	6		173	166	6	1	173	169	4	
Тэсийн илч ХХК	170	120	47	3	173	168	5		173	173		
Галт дулаан ХХК	170	123	47		173	171	2		173	173		
Түнэл илч ХХК	170	66	54	50	173	84	40	49	173	167	6	

**Орон нутгийн өмчит, өмчийн оролцоотой хуулийн этгээдийн зорилтот түвшний
төлөвлөлт, хэрэгжилтийн хураангуй судалгаа**

Хавсралт 2

№	Үзүүлэлт	2019 он		2020 он		2021 он	
		Батлагдсан	Тайлагнасан	Батлагдсан	Тайлагнасан	Батлагдсан	Тайлагнасан
1	Нийт борлуулалтын орлого	22,598.71	20,201.21	23,627.45	21,008.35	24,929.75	24,847.88
2	Нийт зардал	20,643.44	18,405.66	22,472.85	19,661.43	23,850.91	23,495.18
6	Татвар, хураамж, шимтгэл	119.41	1,061.95	71.40	952.57	94.67	1,493.48
8	Борлуулалтын 1 төгрөгт ногдох зардал	89.88	94.52	94.12	85.26	84.44	80.18
9	Нийт авлага	217.64	1,362.09	576.89	2,371.39	1,094.55	2,504.88
9	Нийт өглөг	665.02	5,269.27	665.75	13,734.43	1,796.09	14,248.28
10	Нийт ажиллагсдын тоо	569.00	568.00	565.00	601.00	538.00	561.00
11	Нийт цалингийн сан	5,526.42	4,933.43	5,254.97	5,163.42	5,365.69	5,471.72
12	Нэг ажиллагсдын дундаж цалин	567.87	571.54	577.38	575.18	576.32	579.09
13	Нийт хөрөнгийн дүн	-	49,580.09		62,611.93		64,318.19

ХОЛБОГДОХ БАЙГУУЛЛАГЫН САНАЛ:

**ХӨВСГӨЛ АЙМГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН
ХУРАЛ**


67120, Хөвсгөл аймаг, Мөрөн сум
Нутгийн удирдлагын ордон 3 давхар, Утас: 7038 2764,
Факс: 7038 2554 Э-мэйл: aimginihural@khs.gov.mn
Вэбсайт: Khovsgol.Khural.mn

2022.06.30 № 2/296
танай _____-ны № _____-т

**ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН
АУДИТЫН ГАЗРЫН ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР А.ЭРДЭНЭБААТАР ТАНАА**

“Төрийн болон орон нутгийн өмчит, өмчийн оролцоотой хуулийн этгээдийн үйл ажиллагааны үр ашиг” гүйцэтгэлийн аудитын тайлангийн төсөлтэй танилцлаа.

Аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллах болно.

НАРИЙН БИЧГИЙН ДАРГЫН
АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН
ГҮЙЦЭТГЭГЧ  Р.МАШБАТ

6710091968



**ХӨВСГӨЛ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР**


АЗДТГ-ын байр, Мөрөн сум, Хөвсгөл аймаг, 67120
Утас: 7038 3303, Цахим шуудан: huvsgulzdtg@khs.gov.mn
Цахим хуудас: www.khovsgol.gov.mn

2022.06.30 № 3/1488
танай _____-ны № _____-т

**ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАРТ**

Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газрын гүйцэтгэсэн “Төрийн болон орон нутгийн өмчит, өмчийн оролцоотой хуулийн этгээдийн үйл ажиллагааны үр ашиг” гүйцэтгэлийн аудитын тайлангийн төсөлтэй танилцлаа.

Төсөлд өгөх саналгүй болно.

ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН
ГҮЙЦЭТГЭГЧ  П.АРИУНБАТ

6710091968